

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 01-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1 – 2
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	3 – 31
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	32 – 113

1.	<i>Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал</i>	35 – 37
2.	<i>Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	37 – 45
3.	<i>Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүн 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	45 – 50
4.	<i>Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ./</i>	50 – 62
5.	<i>Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./</i>	62 – 80
6.	<i>■ Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 3 гишүүн 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	80 – 111

- *Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 26 гишүүн 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*
- *Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 11 гишүүн 2025.06.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*
- *Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*
- *Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 9 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*
- *Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нарын 20 гишүүн 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

7. *Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан нарын 40 гишүүн 2025.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 07 дугаар сарын 01-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 68.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 20 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Т.Доржханд, Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Ө.Шижир.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар хэлэлцэх асуудлын жагсаалтад байгаа арван нэг дэх, арван хоёр дахь хоёр асуудлыг хэлэлцэх асуудлын хоёр, гуравт оруулах гэсэн горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Б.Баярсайхан нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүнээс 2025 оны 06 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 8
Бүгд: 16
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ц.Сандаг-Очир: Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн “Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн “Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн “Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5

Бүгд: 16

68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн “Бүгд Найрамдах Тринадад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 5

Бүгд: 16

68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 12 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын зөвлөх Б.Баттөгс нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Б.Баярсайхан нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн тавьсан асуултад Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар хариулж, тайлбар хийв.

Ц.Сандаг-Очир: 1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17
52.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

■ *Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдээр санал хураалт явуулав.*

Ц.Сандаг-Очир: 1.Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 6
Бүгд: 17
64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 8

Бүгд: 17

52.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүн 2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ч.Батбямба, Ж.Түвшинжаргал, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Б.Баярсайхан нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн тавьсан асуултад О.Батнайрамдал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Ц.Сандаг-Очир: Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 11
Бүгд: 19
42.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Сандаг-Очир: Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

■ *Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслөөр санал хураалт явуулав.*

Ц.Сандаг-Очир: 1.Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 10
Бүгд: 19

47.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19

52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Сандаг-Очир: Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 9
Бүгд: 20

55.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Д.Мөнх-Эрдэнэ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга

А.Үйлстөгөлдөр, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Бямбасүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Улсын Их Хурлын Тамгын газрын Менежментийн газрын Санхүү, хангамжийн үйлчилгээний хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Санхүүгийн хэлтсийн дарга Х.Отгонжаргал, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, ар талын газрын дарга Т.Мөнхдорж, Онцгой байдлын ерөнхий газрын Санхүүгийн хэлтсийн дарга Т.Мөнх-Эрдэнэ, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Дэлгэржаргал, Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төрийн сангийн газрын Төлбөр, тооцооны хэлтсийн дарга Н.Саруул, мөн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Алтанхорол, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалтын төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч З.Цэдэнжав, Санхүү, нийцлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Санхүү, нийцлийн аудитын газрын аудитын менежер Б.Долгорсүрэн, Санхүү, нийцлийн аудитын газрын аудитын менежер Б.Лхагвацэнд, А.Цогбаяр, В.Эрдэнэцогт, И.Эрдэнэцэцэг, Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор Ж.Бүжинханд, П.Батцэцэг, Б.Ариунжаргал, Б.Долгоржав, П.Амарсанаа, С.Отгонхорлоо, Т.Мягмаржав, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын аудитын менежер Ю.Энхтуяа, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын ахлах аудитор У.Оюунхүү, мөн газрын аудитор Б.Идэрбалжинням нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Ж.Баярмаа нарын тавьсан асуултад Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Дэлгэржаргал, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, Ц.Сандаг-Очир нар үг хэлэв.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Д.Мөнх-Эрдэнэ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Бямбасүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Улсын Их Хурлын Тамгын газрын Менежментийн газрын Санхүү, хангамжийн үйлчилгээний хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Санхүүгийн хэлтсийн дарга Х.Отгонжаргал, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, ар талын газрын дарга Т.Мөнхдорж, Онцгой байдлын ерөнхий газрын Санхүүгийн хэлтсийн дарга Т.Мөнх-Эрдэнэ, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн

нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төрийн сангийн газрын дарга Б.Цогбадрах, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Дэлгэржаргал, Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төрийн сангийн газрын Төлбөр, тооцооны хэлтсийн дарга Н.Саруул, мөн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Алтанхорол, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалтын төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч З.Цэдэнжав, Санхүү, нийцлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Санхүү, нийцлийн аудитын газрын аудитын менежер Б.Долгорсүрэн, Санхүү, нийцлийн аудитын газрын аудитын менежер Б.Лхагвацэнд, А.Цогбаяр, В.Эрдэнэцогт, И.Эрдэнэцэцэг, Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор Ж.Бүжинханд, П.Батцэцэг, Б.Ариунжаргал, Б.Долгоржав, П.Амарсанаа, С.Отгонхорлоо, Т.Мягмаржав, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын аудитын менежер Ю.Энхтуяа, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын ахлах аудитор У.Оюунхүү, мөн газрын аудитор Б.Идэрбалжинням нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Б.Баярсайхан, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн төслүүдэд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Баярбаатар, Э.Болормаа, О.Алтангэрэл, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 3 гишүүн 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 11 гишүүн 2025.06.10-ны өдөр өргөн мэдүүлсэн/ **Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл** /Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 26 гишүүн 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн/ **Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл** /Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн/ **Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл** /Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 9 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн/ **Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд** /Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нарын 20 гишүүн 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, **анхны хэлэлцүүлэг**/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Б.Батчимэг, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Б.Мажигсүрэн, Б.Нандингэрэл, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Б.Баярсайхан, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Хуулийн төслүүдийг нэгтгэн Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа, Ёс зүй, дэгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат нар танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН НЭГТГЭСЭН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Н.Алтаншагай, П.Сайнзориг, Г.Уянгахишиг, Ө.Шижир /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.26 дахь хэсгийн “Хүний эрхийн Үндэсний Комисс,” гэсний дараа “Үндэсний статистикийн хороо,” гэж, мөн заалтын 21.25, 21.30 дахь хэсгийн “мэдээллийг” гэсний дараа “санаатайгаар” гэж, мөн зүйлийн 5 дахь заалт буюу 23.8.1 дэх заалтын “судлах,” гэсний дараа “холбогдох Байнгын хорооны саналыг үндэслэн тухайн асуудлаар холбогдох байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл авах, сонсох,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 7

Бүгд: 20

65.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгээс гаргасан, Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 21.26 дахь хэсгийн “21.25-д” гэснийг “21.24-д” гэж, мөн заалтын 21.28 дахь хэсгийн “Улсын Их Хуралд” гэснийг, мөн 21.30 дахь хэсгийн “Нэгдсэн хуралдаанд” гэснийг “Улсын Их Хурлын асуулгын цаг, Тусгай хяналтын дэд хорооны сонсгол, Хяналт шалгалтын түр хорооны сонсгол болон Хяналтын сонсголд, эсвэл нэгдсэн хуралдаанаар гишүүний асуулгын хариу, улсын төсөв, төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэхэд” гэж тус тус, мөн 21.28 дахь хэсгийн “тухайн нам, эвслийн бүлэг, эсхүл 10-аас” гэснийг “нам, эвслийн бүлэг, эсхүл 20-оос” гэж, 21.30 дахь хэсгийн “32.7-д” гэснийг “32.8-д” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 6

Бүгд: 20

70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 21.24 дэх хэсгийн “Тусгай хяналтын дэд хороо,” гэсний дараа “Хяналтын сонсгол болон” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 6
Бүгд: 20
70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 22.6.7 дахь заалтын, мөн зүйлийн 4 дэх заалт буюу 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсгийн, мөн зүйлийн 6 дахь заалт буюу 27.3.3 дахь заалтын “Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны” гэснийг “Хүний хөгжил, нийгмийн бодлогын” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 6
Бүгд: 20
70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтыг “22.6.7.Нийгмийн бодлогын” гэж өөрчлөх, мөн зүйлийн 4 дэх заалтаас 23.7.1, 23.7.3, 23.7.4, 23.7.6, 23.7.7, 23.7.8, 23.7.11 заалтыг, мөн зүйлийн 6 дахь заалтаас 27.3.3 дахь заалтыг, мөн зүйлийн 7 дахь заалтаас 27.5.6 дахь заалтыг, 6 дугаар зүйлээс 22.6.4, 23.4 гэснийг тус тус хасах, мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлээс 115 дугаар зүйлийн 115.2.8, 115.2.12, 115.2.16 дахь заалтын “Нийгмийн

бодлогын” гэснийг “Нийгмийн бодлого, боловсрол, шинжлэх ухааны” гэснийг хасах тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 14
Бүгд: 20
30.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтыг “22.6.7.Нийгмийн бодлогын” гэж өөрчлөх, мөн зүйлийн 4 дэх заалтаас 23.7.1, 23.7.3, 23.7.4, 23.7.6, 23.7.7, 23.7.8, 23.7.11 дэх заалтыг, мөн зүйлийн 6 дахь заалтаас 27.3.3 дахь заалтыг, мөн зүйлийн 7 дахь заалтаас 27.5.6 дахь заалтыг, төслийн 6 дугаар зүйлийн “22.6.4-22.6.6” гэснийг “22.6.5, 22.6.6” гэж өөрчилж, 23.4 гэснийг хасах, мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлээс 115 дугаар зүйлийн 115.2.8, 115.2.12, 115.2.16 дахь заалтын “Нийгмийн бодлогын” гэснийг “Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 16
Бүгд: 20
20.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтыг “22.6.7.Нийгмийн бодлогын” гэж өөрчлөх, мөн зүйлийн 4 дэх заалтаас 23.7.1, 23.7.3, 23.7.4, 23.7.6, 23.7.7, 23.7.8, 23.7.11 дэх заалтыг, мөн зүйлийн 6 дахь заалтаас 27.3.3 дахь заалтыг, мөн зүйлийн 7 дахь заалтаас 27.5.6 дахь заалтыг, төслийн 6 дугаар зүйлийн “22.6.4-22.6.6” гэснийг “22.6.5, 22.6.6” гэж өөрчилж, 23.4 гэснийг хасах, мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлээс 115 дугаар зүйлийн 115.2.8, 115.2.12, 115.2.16 дахь заалтын “Нийгмийн бодлогын” гэснийг “Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 15
Бүгд: 20
25.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтыг “22.6.7.Нийгмийн бодлогын” гэж өөрчлөх, мөн зүйлийн 4 дэх заалтаас 23.7.1, 23.7.3, 23.7.4, 23.7.6, 23.7.7, 23.7.8, 23.7.11 дэх заалтыг, мөн зүйлийн 6 дахь заалтаас 27.3.3 дахь заалтыг, мөн зүйлийн 7 дахь заалтаас 27.5.6 дахь заалтыг, төслийн 6 дугаар зүйлийн “22.6.4-22.6.6” гэснийг “22.6.5, 22.6.6” гэж өөрчилж, 23.4 гэснийг хасах, мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлээс 115 дугаар зүйлийн 115.2.8, 115.2.12, 115.2.16 дахь заалтын “Нийгмийн бодлогын” гэснийг “Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 14
Бүгд: 20
30.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 6, 7 дахь заалтуудыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Төслийн 6 дахь заалтын 27.3.7 дахь заалтаас “Жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн” гэснийг, 7 дахь заалтын “27.5.4” дэх заалтыг тус тус хасах. Мөн 3 дугаар зүйлийн 22.6 дахь хэсэгт “Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо” гэж нэмэх, 6 дугаар зүйлээс 22.6.1, 23.1 гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 16
Бүгд: 20
20.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 27 дугаар зүйлийн 27.3.3 дахь заалтын, мөн зүйлийн 7 дахь заалт буюу 27.5.14 дэх заалтын “Шинжлэх ухааны” гэснийг “Боловсрол, шинжлэх ухааны” гэж, 27.5.1 дэх заалтын “асуудлаарх” гэснийг “талаарх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 6
Бүгд: 20
70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 27 дугаар зүйлийн 27.3.7 дахь заалтын “Эдийн засгийн байнгын хороонд” гэсний дараа “аялал жуулчлалын хөгжлийн,” гэж нэмж, мөн зүйлийн 7 дахь заалтад доор дурдсан агуулгатай 27.5.2 дахь заалт нэмэх:

“27.5.2.Аялал жуулчлалын хөгжлийн дэд хороо нь аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын асуудлыг,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 5

Бүгд: 20

75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалтын 27.3.6 дахь заалтын “Хууль сахиулах ажиллагааны тухай хяналтын” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1

Татгалзсан: 19

Бүгд: 20

5.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 27.5.9 дэх заалтын “тагнуулын гүйцэтгэх” гэснийг “тагнуулын болон гүйцэтгэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1

Татгалзсан: 19

Бүгд: 20

5.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 27.5.11 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1

Татгалзсан: 19

Бүгд: 20

5.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгээс гаргасан, Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 27.5.9 дэх заалтын “тагнуулын гүйцэтгэх” гэснийг “тагнуулын болон цэргийн тагнуулын байгууллагын гүйцэтгэх” гэж өөрчилж, мөн зүйлийн 27.5.11 дэх заалтын “явуулж байгаа” гэсний дараа “тагнуулын болон цэргийн тагнуулын байгууллагад харьяалуулснаас бусад” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 5

Бүгд: 20

75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 5 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 6 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 7 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгээс гаргасан, Нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томьёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 5
Бүгд: 20
75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН НЭГТГЭСЭН
ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 69¹ дүгээр зүйлийн 69^{1.3} дахь хэсгийн “Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт төсвийн төслийн талаарх илтгэлийг Ерөнхий сайд танилцуулна.” гэснийг хасаж, мөн хэсгийн “илтгэлд” гэснийг “танилцуулгад” гэж, мөн зүйлийн “69^{1.5} дахь хэсгийн 69^{1.3}-т” гэснийг “69^{1.4}-д” гэж, мөн зүйлийн 3 дахь заалт буюу 73^{1.1} дэх хэсгийн “хууль болон хамт баталсан хууль, тогтоолд” гэснийг “хуульд” гэж, “хууль, тогтоол” гэснийг “хуулийг” гэж, “хоригийн шинж байдлыг харгалзан” гэснийг “Төсвийн байнгын хорооны саналаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 7
Бүгд: 20
65.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд тусгасан Улсын Их Хурлаар төсөв хэлэлцэхтэй холбоотой 69¹ дүгээр зүйлийг хасах гэсэн дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 8
Бүгд: 20

60.0 хувийн саналаар Төсвийн байнгын хорооны санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 64.1.1 дэх заалтын “, үг хэлэх” гэснийг “үг хэлж болно. Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороод, Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлнэ,” гэж, 64.1.3 дахь заалтыг “үг хэлэх” гэснийг “үг хэлж болно. Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 64.1.2-т заасан “санал тус бүрээр ил санал хураалт явуулна,” гэж өөрчилж, 64.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“64.1.2.хоёр дахь хэлэлцүүлгээр Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, гаргасан саналыхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно. Байнгын хороод зарчмын зөрүүтэй санал тус бүрээр санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томъёолж, зарчмын зөрүүтэй саналын томъёололыг санал, дүгнэлтийн хамт Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ. Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо хамтарсан хуралдаанаар Байнгын хороодын санал нэг бүрийг хэлэлцэж, ил санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томъёолж, санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулах” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 7
Бүгд: 20

65.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 64.1.4 дэх заалтын “төсвийн” гэснийг хасаж, 64.1.5 дахь заалтын “танилцуулгын талаар гишүүд тайлбар хийж, түүнтэй холбогдуулж асууж” гэснийг “танилцуулахтай холбогдуулан гишүүд асуулт асууж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 7

Бүгд: 20

65.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 69 дүгээр зүйлийн 69.1.4 дэх заалтын “хоёр дахь” гэснийг “3 дахь” гэж өөрчилж, мөн зүйлийн 4 дэх заалт буюу 70.3 дахь хэсгийн “төслийн талаар” гэснийг “төслийн хэлэлцүүлэг хийсэн талаар” гэж, мөн зүйлийн 70.1, 70.3 дахь хэсгийн “Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, нам, эвслийн бүлэг” гэснийг, 70.2 дахь хэсгийн “болон дэд” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 7

Бүгд: 20

65.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн “35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийн “дүгнэлт болон төсвийн нөлөөллийн дүн шинжилгээг” гэснийг “зөвлөмжийг” гэж,” гэснийг хасаж, мөн зүйлийн “42.2.2 дахь заалтын” гэснийг дараах “дүгнэлтийг” гэснийг “энэ хуулийн 34.1-д заасан хууль зүйн дүгнэлтийг” гэж, мөн зүйлийн “Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны” гэснийг “Хүний хөгжил, нийгмийн бодлогын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 8

Бүгд: 20

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Нэгтгэсэн төслийн 5 дугаар зүйлийн “70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсэг,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 5

Бүгд: 20

75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 5 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 6 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 7 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН НЭГТГЭСЭН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл хариулж, тайлбар хийв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйл буюу 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Түр хорооны даргаар түр хороо байгуулах саналыг анх санаачилсан гишүүнийг томилж ажиллуулах бөгөөд уг гишүүн өөрөө татгалзсан тохиолдолд түр хороо байгуулах санал тавьсан бусад гишүүд дотроосоо түр хорооны даргаа олонхын саналаар сонгоно. Хэрэв түр хороо байгуулах санал тавьсан гишүүд даргаа дотроосоо сонгох шаардлагагүй гэж үзвэл түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 7

Бүгд: 20

65.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Төслийн 2 дугаар зүйлийн “Тогтвортой” гэснийг “Төсвийн тогтвортой” гэж өөрчилж, “24 дүгээр зүйлийн” гэсний дараа “24.2, 24.3 дахь хэсгийн “Хоёр” гэснийг “Гурав” гэж, мөн зүйлийн 24.2 дахь хэсгийн “хоёр” гэснийг “гурав” гэж,” гэж нэмж, “, 24.4 дэх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 6

Бүгд: 20

70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 5 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

**ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
НЭГТГЭСЭН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН
ТОМЬЁОЛОЛ:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Нэгтгэсэн хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “чуулганы нэгдсэн хуралдаанд” гэснийг “тухай хуулийн 21.28, 21.30-д заасан асуудлаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 5

Бүгд: 20

75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

- Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.5 дахь заалтын “гүйцэтгэх ажлын” гэснийг “гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажиллагааны” гэж: мөн заалтын “тусгай хяналтын” гэснийг “хууль сахиулах тусгай хяналтын” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0

Татгалзсан: 20

Бүгд: 20

0.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

- Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн Авлигын эсрэг хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн “гүйцэтгэх ажлын” гэснийг “гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажиллагааны” гэж, мөн заалтын “тусгай хяналтын” гэснийг “хууль сахиулах тусгай хяналтын” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0

Татгалзсан: 20

Бүгд: 20

0.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

- Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан нарын 40 гишүүн 2025.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, **анхны хэлэлцүүлэг**/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүн Э.Одбаяр хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах гэсэн горимын санал гаргав.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Э.Одбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 7
Бүгд: 20
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 08 минут үргэлжилж, 25 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 28 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
12 цаг 20 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны ирц хүрсэн тул Байнгын хороо хуралдаанаа эхэлье.

Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Хуралдааны ирцийг Оюунсайханы Алтангэрэл гишүүн ирсэн, Жадамбаагийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн, Батын Батбаатар, Баярмагнайн Баярбаатар, Энхбатын Болормаа, Сандагийн Бямбацогт, Лувсаннъямын Гантөмөр, Сархадын Зулпхар, Одсүрэнгийн Номинчимэг, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Цэвэгдоржийн Туваан, Ням-Осорын Учрал, Гончигдоржийн Уянгахишиг, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан нарын гишүүд ирж хуралдааны ирц 60 хувьтай байгаа учраас Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал.

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Засгийн газар 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хоёр дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ.

Гурав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд

өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд.

Засгийн газар 2025 оны 06 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хоёр дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

Дөрөв.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 3 гишүүн 2025 оны 03 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

Тав.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 26 гишүүн 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

Зургаа.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 11 гишүүн 2025 оны 06 сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

Долоо.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 10 гишүүн 2025 оны 06 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

Найм.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 9 гишүүн 2025 оны 06 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

Ес.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нарын 20 гишүүн 2025 оны 06 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

Арав.Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан нарын 40 гишүүн 2025 оны 06 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

Арван нэг. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл.

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүн 2025 оны 06 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.

Арван хоёр. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Засгийн газар 2025 оны 06 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.

Хэлэлцэх асуудлуудыг танилцууллаа.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? С.Зулпхар гишүүн байна.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Энэ Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээр Монгол Улсын төсөв, Үндэсний баялгийн сангийн тухай, Төсвийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэлэлцээд байгаа юм байна.

Тэгээд энэ дарааллын хоёрт байгаа юм. Орж ирж арай амжихааргүй юм байна.

Гэхдээ бид зохион байгуулалтын хувьд цагаа ашиглаад энэ дарааллын 11, 12-т байж байгаа. Б.Уянга гишүүний санаачилсан Нийтээр тэмдэглэх баярын өдрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэлэлцвэл яасан юм бэ гэсэн горимын саналтай байна.

Ц.Сандаг-Очир: С.Зулпхар гишүүн горимын санал гаргаж байна.

Хажуу талд Үйлдвэржилтийн байнгын хороо хуралдаж байгаа.

Тэнд 2024 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан юмнууд орж байгаа учраас хэлэлцэх асуудлын 11-д байгаа Нийтээр тэмдэглэх баярын болон

тэмдэглэлт өдрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг, мөн 12 дээр байгаа Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх асуудлын 2, 3 дугаарт хэлэлцье гэсэн горимын санал гаргаж байна. Хажуу талд аж үйлдвэрт дуусаагүй байна. Тийм.

Тэгэхээр санал хураалт. Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй.

С.Зулпхар гишүүний гаргасан 11 дэх, 12 дахь хэлэлцэх асуудлын жагсаалтад байгаа хоёр асуудлыг хэлэлцэх асуудлын 2, 3-д оруулъя гэсэн горимын санал гаргаж байна.

Горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

16 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 68.8 хувиар С.Зулпхар гишүүний гаргасан горимын санал дэмжигдлээ.

Хэлэлцэх асуудлын дарааллын 2, 3-д 11, 12-т байгаа асуудлууд орж ирсэн.

Хэлэлцэх асуудал батлагдлаа. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын
2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй
хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар
хэлэлцүүлэх эсэх асуудал**

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье.

1.Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүнээс 2025 оны 06 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

О.Номинчимэг гишүүн горимын санал гаргая.

О.Номинчимэг: Саяын санал хураалт дээр төхөөрөмж ажилласангүй. Хүчингүй болгож дахин санал хураалт явуулж өгнө үү.

Ц.Сандаг-Очир: Гишүүд санал хураалтад бэлдээрэй.

Саяын үндсэн санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

16 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 62.5 хувиар санал дэмжигдлээ.

Жудагийн Баярмаа гишүүнийг дэмжсэнд протоколд тэмдэглүүлээрэй.

Үндсэн санал хураалттай юм байна. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

16 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 68.8 хувиар санал дэмжигдлээ.

2.Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн “Барбадос Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

16 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 56.3 хувиар санал дэмжигдлээ.

3.Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн “Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

16 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 62.5 хувиар санал дэмжигдлээ.

4.Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн “Эсватинийн Хаант Улс тай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

16 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 68.8 хувиар санал дэмжигдлээ.

5.Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн “Бүгд Найрамдах Тринадад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлгийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

16 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 68.8 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаараар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Нэг дэх асуудал хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудалд оръё.

**Хоёр.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний
түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон
хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/**

Хоёр дахь асуудал. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Засгийн газар 2025 оны 06 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх асуудалд оръё.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Энхтайваны Бат-Амгалан хийнэ.

Э.Бат-Амгалан гишүүний микрофоныг өгье.

Э.Бат-Амгалан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3.2.5-д хот суурин газрын гэр хорооллыг иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөх, төвлөрсөн, хэсэгчилсэн, бие даасан инженерийн дэд бүтцэд холбогдсон орон сууцын хороолол болгон хөгжүүлэх, Хотын авто замын бүсчлэлийг тогтоож, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах гэж, 3.2.13-д гэр хорооллын дундын болон захын бүсийг тэргүүн эгнээнд инженерийн дэд бүтэцтэй болгоход улс, орон нутгийн төсөв болон бусад хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зориулах, иргэдийн хүсэл санаачилгад үндэслэн дэд бүтэц бүхий газрыг төр, эсвэл хувийн хэвшлийн орон сууцаар шууд солих замаар дараагийн орон сууц баригдах талбайг бий болгоно гэж заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1, 4.4-т Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний удирдлагын системд хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологийг нэвтрүүлж, гэрлэн дохионы зохицуулалтыг хөдөлгөөний урсгалаас хамаарч ухаалгаар зохицуулах боломжийг бүрдүүлнэ гэж, 1.1.3.1-д Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу дэд төвийн орчмын газрыг үргэлжлүүлэн чөлөөлж, нийгмийн болон инженерийн дэд бүтцийг барих, 20 мянган айлын орон сууцжуулах үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж, Толгойт, Шар хад, Дэнжийн мянга, Дамбадаржаа, Яармаг дэд төвүүдийн инженерийн дэд бүтцийг барьж байгуулна гэж заасан.

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнтэй холбоотой эдийн засаг, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг авах зорилгоор нийслэл рүү чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн эрчимтэй нэмэгдэж, 1990 онд 560.6 мянган хүн хүн амтай байсан нийслэл Улаанбаатар хот 2000 онд 747.1 мянга, 2010 онд 1 сая 112 мянга, 2025 онд 1 сая 768 мянган хүн амтай болж өссөн бөгөөд үүнтэй холбоотой авто замын түгжрэл, агаарын бохирдол, гэр хорооллын тэлэлт гэх мэт үр дагаврыг бий болгоод байна.

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулийн зорилт нь иргэдийг саадгүй зорчих нөхцөл, нийтийн тээврийн төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, авто зогсоолын ашиглалтыг сайжруулах, хотын төвлөрлийг сааруулж гэр хорооллыг орон сууцжуулах, орчны бохирдлоос үүсэх нийгэм эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах асуудал юм.

Хуулийг хэрэгжүүлж эхэлсэн нэг жил 6 сарын хугацаанд нийслэлийн нийтийн тээврийн шинэчлэл, авто зогсоолын менежмент, нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх асуудал, гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагаа шинэ шатанд гараад байна.

Судалгаанаас харахад нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийг батлагдах хүртэл хугацаанд буюу 2015 онд 72, 2016 онд 145, 2017 онд 253, 2018 онд 924, 2019 онд 576, 2020 онд 354, 2021 онд 138, 2022 онд 744, 2023 онд 202 нэгж талбарыг чөлөөлсөн бол хууль батлагдсаны дараа буюу 2024 онд 2082 нэгж талбарыг чөлөөлөөд байна.

Нийслэлийн агаар, хөрс, орчны бохирдлын асуудлыг шийдвэрлэх, авто замын түгжрэлийг бууруулах, иргэдийн амьдрах таатай орчин нөхцөлийг сайжруулах үндсэн шийдэл, оновчтой гарц нь гэр хорооллыг инженерийн дэд бүтцээр хангах, дахин төлөвлөж барилгажуулах асуудал юм.

Ирэх жилүүдэд 20 минутын хот үзэл баримтлалын хүрээнд нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, агаар, орчны бохирдлыг бууруулах, иргэдийн амьдралын чанарын дээшлүүлэх зорилгоор үндэсний хэмжээнд дэд бүтцийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртөж байгаа иргэн, хуулийн этгээдийн газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг дан ганц орон нутгийн төсвөөс шийдвэрлэх боломжгүй нөхцөл үүсээд байгаа бөгөөд газрыг өөрийг нь эргэлтэд оруулж, асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 86 дугаар тогтоолоор Нийслэлийн “Теле камерын нэгдсэн төв” байгуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид даалгасан бөгөөд Нийслэлийн “Теле камерын нэгдсэн төв” болон 9 дүүргийн Засаг даргын дэргэд Телекамерын хяналтын дэд төвүүдийг байгуулаад байна.

Улаанбаатар хотын 176 уулзвар, гарц, авто замд 2606 камер суурилуулж, 10 төрлийн зөрчлийг хиймэл оюунд суурилсан систем ашиглан илрүүлэх нөхцөл бүрдсэн.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэрээр боловсрууллаа.

Тодруулбал нийслэл хотын газрыг дахин төлөвлөх, гэр хорооллыг орон сууцжуулах, агаар, хөрсний бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлтийг дэмжих, орон сууцын санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх зориулалттай газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сангийн зохицуулалт, мэдээллийн систем, хиймэл оюун ашиглаж замын хөдөлгөөний урсгалыг оновчтой зохион байгуулах, түгжрэлийг

бууруулах, аюулгүй байдлыг хангах, зөрчил илрүүлэх, ослын хяналтыг сайжруулах зохицуулалт, гэр хорооллыг орон сууцжуулах төслийн хүрээнд баригдсан орон сууцыг газар чөлөөлөлтийн болон газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор борлуулах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулж, иргэдийн саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, гэр хорооллыг орон сууцжуулж, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, агаар, орчны бохирдлоос үүсэх нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах зорилтын хүрээнд хуулийн төсөлтэй холбогдуулан Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Ц.Сандаг-Очир: Э.Бат-Амгалан сайдад баярлалаа.

Одоо хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу?

Асуултын өмнө ажлын хэсгийг танилцуулъя.

Х.Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, М.Үнэнбат Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Б.Баттөгс Хот байгуулалт барилга, орон сууцжуулалтын сайдын зөвлөх.

Хуулийн төсөл, үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Г.Уянгахишиг гишүүнээр тасаллаа.

Г.Уянгахишиг гишүүн асуултаа асууя.

Г.Уянгахишиг: Ажлын хэсэгт өдрийн мэнд хүргэе. Гишүүддээ ч гэсэн.

Ер нь хуулийн үзэл санааг дэмжиж, байгаа. Эндээс зүгээр нэг л тодруулах юм байна. Энэ 7⁶ дээр газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сангийн тайлан зарцуулалт ил тод, нээлттэй байна гэсэн байгаа.

Тэгэхээр яг энэ ил тод, нээлттэй байлгахыгаа яг ямар журмаар төсөөлж байгаа вэ буюу ямар давтамжтайгаар, ямар эх үүсвэр, мэдээллийн эх сурвалжаар нээлттэй байлгах вэ гэдэг дээр нэг тодруулга авчихъя.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 дахь микрофон.

Х.Нямбаатар: Г.Уянгахишиг гишүүний асуултад хариулъя.

Газрыг дахин төлөвлөх Гэр хорооллын хөгжлийн санг дараах хөрөнгийн эх үүсвэрээс бүрдэнэ гэж бид тооцож байгаа.

▷ **Нэгдүгээрт**, орон нутгийн төсөв.

▷ **Хоёрдугаарт**, гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд бий болсон орон сууцуудыг

- ▶ худалдан борлуулснаас орох орлого,
- ▶ газрыг дахин төлөвлөх хүрээнд газрыг дуудлага худалдаагаар худалдан борлуулсны орлого,
- ▶ хуулиар хориглоогүй бусад хандив

гэсэн ийм төрлүүдээс “газрын сан” бүрдэхээр төлөвлөж байгаа юм.

Тухайлах юм бол Дэнжийн мянга дээр баригдаж байгаа 1008 айлын орон сууцыг Хөгжлийн банкны барьцаанд тавьсан байгаа. Угтаа уг барилгын зориулалт нь Монгол Улсын Засгийн газарт Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас буцалтгүй тусламж байдлаар олгоод, газрын сандаа зориулаарай гэж уг нь анх зориулалтаар ирсэн юм.

Одоо Азийн хөгжлийн банк, Уур амьсгалын өөрчлөлтийн ногоон сангийн санхүүжилтээр Баянхошуу, Шар хаданд 800 гаруй айлын орон сууц ашиглалтад орох гэж байна.

Тэгэхээр бид өмнө нь яг ийм алдаануудыг маш их давтсан. Өөрөөр хэлбэл үүнийг хэн нэг ахмад настан, хэн нэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд буцалтгүй тусламж байдлаар өгөөд сан бүрдүүлж явж чаддаггүй, эргээд газар чөлөөлөлтийн эх үүсвэргүй байсан учраас одоо бид яаралтай энэ хуулийг батлуулснаар эдгээр олон жилийн хугацаатай эргэн төлөгдөх нөхцөлтэй гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд баригдаж байгаа орон сууцуудыг зарж борлуулсан орлогоороо газар чөлөөлөлтийн сан үүсгэе гэж байгаа юм.

Үүсгэсэн сангийн дүрмийг Нийслэлийн Засаг дарга батална. Харин санг захиран зарцуулах, түүнд хяналт тавих тэр журмыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батлахаар байгаа.

Санг юунд зориулах вэ гэхээр санг дараах зүйлд зориулна.

➤ **Нэгдүгээрт**, газар чөлөөлөлтөд зориулна.

➤ **Хоёрдугаарт**, чөлөөлсөн газар дээрээ инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц татахад зориулна.

Мөн ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн орон сууцыг дахин барилгажуулахад зориулахаар. Өөр ямар нэгэн зориулалтаар зарцуулахгүй байхаар явж байгаа.

Тэгээд мэдээж хэрэг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ журмыг батлахаар

➤ Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Захиргааны актын бүртгэлд бүртгэгдэнэ.

➤ Журмын хүрээнд өөрт нь хяналт тавьдаг хөндлөнгийн хяналт аудитын хороод давхар ажиллана.

➤ Хуульд заасан зөвхөн энэ үндэслэл журмаар санг зарцуулна.

➤ Хуульд заасан үндэслэл, журмаар санг бүрдүүлнэ гэж хэлж байгаа юм.

Ер нь бид өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд их том алдаа гаргасан байна лээ. Өөрөөр хэлбэл газрын дуудлага худалдаа гэдэг ойлголтыг хөгжүүлж чадаагүй.

Сая бид Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 3100 метр квадрат газрыг сая дуудлага худалдаагаар худалдахад 9.3 тэрбум төгрөг бүрдсэн.

Цаашид бид Улаанбаатар хотод зарим өөрийн өмчлөлийн болон ашиглалтын шаардлага хангахгүй газрууд дээрээ дуудлага худалдаа зохион байгуулахад энэ санд тодорхой хэмжээний орлого бүрдэхээр байгаа.

Ц.Сандаг-Очир: Г.Уянгахишиг гишүүн тодруулъя.

Г.Уянгахишиг: Ямар ч байсан сангийн тайлан, зарцуулалт ил тод байх гэдэг зарчмаа журамдаа тусгаад явах юм байна гэж ойлголоо. Тийм ээ.

Бас нэг тодруулмаар байгаа нь 7^{3.4} дээр орон сууцын бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүүгийн зөрүүг төлөх гэж байгаа.

Тэгэхээр яг энд ямар хүүгийн зөрүүний тухай яригдаж байгаа билээ? Яг үүний цаана яг ямар асуудлыг шийдвэрлэхийг зорьж байгаа вэ гээд.

Ц.Сандаг-Очир: Хотын дарга. Ажлын хэсгийн 5 дахь микрофон.

Х.Нямбаатар: Намайг Нийслэлийн Засаг дарга болохоос өмнөх хотын дарга нар орон сууцын бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж, Монголбанкнаас эх үүсвэр татсан.

Татсан эх үүсвэрүүд нь өөрөө 12 хувийн хүүтэй. Иргэдэд буцаагаад нөгөө баригдсан орон сууцаа ипотекийн зээлээр гаргахдаа 6 хувьтай гаргаж байгаа. Өөрөөр хэлбэл энэ хоёрын зөрүү байгаа.

Цаашид бид зах зээлийн бус зарчимтай алдагдал үүсгэхгүй байх зарчмыг баримталж байгаа. Одоо үлдэгдэл төлбөр арван хэд орчим тэрбум төгрөгийн төлбөр үлдсэн байгаа. Түүний хүүгийн зөрүүг төлж дуусгах зайлшгүй шаардлагууд байгаа.

Ц.Сандаг-Очир: Хууль санаачлагчийн илтгэл, хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Одоо хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. /алх цохив/

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлж дууслаа. /алх цохив/

Гишүүд санал хураалтад бэлдье. Гишүүд ээ, санал хураалтдаа бэлдээрэй.

1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

17 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 52.9 хувиар санал дэмжигдлээ.

2.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

17 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 64.7 хувиар санал дэмжигдлээ.

3.Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

17 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 64.7 хувиар санал дэмжигдлээ.

4.Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

17 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 58.8 хувиар санал дэмжигдлээ.

5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

17 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 64.7 хувиар санал дэмжигдлээ.

6.Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

10 гишүүн дэмжиж, 58.8 хувиар санал дэмжигдлээ.

7.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

10 гишүүн дэмжиж, 58.8 хувиар санал дэмжигдлээ.

8.Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

10 гишүүн дэмжиж, 58.8 хувиар санал дэмжигдлээ.

9.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

10 гишүүн дэмжиж, 58.8 хувиар санал дэмжигдлээ.

10.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

10 гишүүн дэмжиж, 58.8 хувиар санал дэмжигдлээ.

11.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

9 гишүүн дэмжиж, 52.9 хувиар санал дэмжигдлээ.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг гишүүн танилцуулна.

Хоёр дахь асуудлыг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Гурав дахь асуудалдаа оръё.

**Гурав.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай
хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон
хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл
/Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүн
2025.06.27-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/**

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл.

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нарын 2 гишүүн 2025 оны 06 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал танилцуулна.

О.Батнайрамдал гишүүний микрофоныг өгье.

О.Батнайрамдал: Өдрийн мэнд хүргэе гишүүддээ.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай 4 дүгээр зүйлд 7 дугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15-ны өдрүүдэд Үндэсний баяр наадам Ардын хувьсгалын ойн баярыг, Цагаан сарыг билгийн тооллын хаврын тэргүүн шир тэргүүн сарын шинийн 1, 2, 3-ны өдрүүдэд, шинэ жилийг 01 дүгээр сарын 01-ний өдөр, Олон улсын эмэгтэйчүүдийн өдрийг 03 дугаар сарын 08-нд, Хүүхдийн баярыг 06 дугаар сарын 01-ний өдөр, Үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолоо сэргээсний баярыг 12 дугаар сарын 29-ний өдөр, Их эзэн Чингис

хааны өдрийг Их эзэн Чингис хаан мэндэлсний билгийн тооллын өвлийн тэргүүн сарын шинийн 01-нд, Бүгд Найрамдах Улс тунхагласны өдрийг 11 дүгээр сарын 26-нд, Бурхан багшийн их дүйчин өдрийг билгийн тооллын зуны тэргүүн сарын шинийн 15-ны өдөр нь тэмдэглэн өнгөрүүлэхээр тус тус тогтоосон болно.

1999 оны 05 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн 77.3 дахь хэсэгт “Нийтээр амрах баярын өдөр долоо хоног бүрийн амралтын өдөр ойрхон тохиосон тохиолдолд долоо хоногийн ажил амралтын өдрийг Засгийн газрын шийдвэрээр зохицуулж болно.” гэсэн заасны дагуу тэмдэглэн өдрүүдүүлж байсан боловч 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тус зохицуулалт тусгагдаагүй байна.

Өөрөөр хэлбэл нийтээр амрах баярын өдрүүдэд нийтээр амрах өдөр буюу амралтын өдөртэй давхацсан тохиолдолд хэзээ тэмдэглэх, уг асуудлыг хэн шийдвэрлэх нь тодорхойгүй байх бөгөөд энэ ажил олгогчийн зүгээс шийдвэрлэх эрх зүйн хэм хэмжээ мөн хуульд тусгагдаагүй байна.

Иймд нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах хэрэгцээ шаардлагыг үндэслэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-д заасны дагуу холбогдох хуулийн төсөлд нэмэлт оруулах хуулийн төслийг бэлтгэлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Дэмжиж өгнө үү. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү.

Б.Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Г.Уянгахишиг гишүүн асуултаа асууя.

Г.Уянгахишиг: Энэ нэлээн удаан яригдаж байсан асуудлыг хуулийн төсөл болгоод оруулж ирсэнд баярлалаа.

Хуулийн төслийг дэмжиж, байна.

Нэг асуулт байгаа нь тайлбар хэсэг заавал чухал уу, үгүй юу гэдэг нэг асуулт байгаад байна. Өөрөөр хэлэх юм бол нэгэнтээ баярын өдөр, амралтын өдрүүдээ дамжаад үргэлжилсэн тохиолдолд дараагийн ажлын өдөрт шилжүүлнэ гэсэн учраас угаасаа ажлын өдөр нь нөгөө дараагийн 3 дахь, 4 дэх нь л байна гэсэн үг байхгүй юу.

Тэгэхээр тайлбар бараг шаардлагагүй юм биш үү гэдэг ийм асуулт.

Ц.Сандаг-Очир: О.Батнайрамдал гишүүн хариулъя.

О.Батнайрамдал: Сүүлийн 2 жил ялангуяа энэ хууль дээр жоохон хийдэл гарахаараа Засгийн газрын шийдвэр гарах болох ч юм шиг, болохгүй ч юм шиг. Уг нь Засгийн газрын шийдвэрээр зохицуулдаг байсан нь алга болохоор тэгээд Засгийн газар нэг шийдвэр гаргаад зөвшөөрсүгэй гээд гаргаж байсан. Тийм ээ.

Тэгэхээр энэ нь сая цагаан сараар бид бөөн маргаан болсон. Та бүхэн бүгдээрээ санаж байгаа байх.

Тийм учраас хуулийн хийдлийг нь уг нь энгийн зарчмаар шийдэх боломжтой байгаа юм.

Яах вэ, тайлбар оруулсан шалтгаан нь одоо үндэсний баяр наадам удахгүй боллоо.

Тэгэхээр үндэсний баяр наадамд хагас сайн, бүтэн сайн яг нөгөө амралтын 6 хоногийн 3, 4 дэх дээр яг тэг дунд нь таарч байна.

Тэгэхээр энэ бас яах вэ бас нэг талаасаа ховор тохиолдол. Гэхдээ арагшаагаа ч 2 өдөр, урагшаагаа ч 2 өдөр илүү байгаа учраас дахиад нэг Засгийн газрын шийдвэр гарах ёстой юм шиг. Гаргая гэхээр хуулийн заалт нь байхгүй. Тийм ээ.

Тэгэхээр энэ дээр маш ойлгомжтой байдлаар оруулаад тайлбар нэмсэн нь зөв болов уу л гэж тухайн үедээ бид бодож гэж оруулсан байгаа юм.

Тийм учраас яг энэ 6 хоног дараалан нийтээр тэмдэглэх баярын өдрүүд Пүрэв, Баасан, Бямба, Ням, Даваа гарагт тохиох юм бол тэр Бямба, Ням гараг гол дунд нь тохиож байгаа учраас тэрийг нь дараагийн өдөр нь буюу Лхагва, Пүрэв гарагт тус тус шилжүүлнэ гэдгийг бүр ингээд маш ойлгомжтойгоор л тайлбарлаж өгч байгаа юм л даа.

Яагаад гэхээр маргаан дагуулаад байсан учраас. Гэхдээ яах вэ, хууль дээрээ энэ дараагийн ажлын өдөр шилжүүлнэ гэсэн учраас энэ тайлбар ер байхгүй байсан ч болно. Зүгээр гэхдээ ойлгомжтой гэх үүднээсээ л оруулсан юм. Тийм.

Ц.Сандаг-Очир: Болсон уу?

О.Батнайрамдал: Болсон.

Ц.Сандаг-Очир: Г.Уянгахишиг гишүүн болсон уу?

Г.Уянгахишиг: Болсон.

Ц.Сандаг-Очир: Б.Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Өнгөрсөн цагаан сартай холбоотойгоор иргэдийн шүүмжлэл нэлээн гараад. Тэгээд үүнийхээ дагуу Засгийн газар 3 сард хууль өргөн барьсан юм л даа.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас энэ хуулийг өргөн барьсан. Тэгээд энэ хуулиа хэлэлцэхгүй байж байгаад яг түүнтэй бүх зүйл нь бүгдээрээ адилхан хуулийг гишүүд бичээд ороод ирж байна л даа. Бүх юм нь адилхан шүү.

Засгийн газрынхаа хуулийг яагаад хэлэлцээгүй юм? Өөрөөр хэлбэл яг ийм агуулга бүхий хуулийг Засгийн газар 3 сард өргөн барьсан байхгүй юу даа. Тэгээд тэр хуулийг хэлэлцээгүй. Одоо хүртэл хэлэлцээгүй байгаа. Яг тэр хуулийг бүгдийг нь тэр чигээр нь хуулаад л аваад ороод ирсэн байна.

Та нар Засгийн газрын өргөн барьсан тэр хувилбарыг үзээрэй. Тэгээд гишүүд хууль баталж нэг тоогоо л нэмж байгаа л юм шиг л харагдаад байх юм.

Ц.Сандаг-Очир: Үг хэллээ. Тийм ээ.

Гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй. Санал хураалт. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

Б.Пүрэвдорж гишүүн горимын санал гаргая.

Б.Пүрэвдорж: Сая гишүүд санал хураалтад бэлтгэх тэр товчоо дарахгүй байж байгаад хоцорчихлоо.

Тийм учраас энэ саналыг хүчингүй болгож, дахин хурааж өгөхийг хүсэж байна.

Ер нь хурдан хурдан шуурхай санал хураалтууд яваад байгаа тохиолдолд заавал бэлтгэх шаардлагагүйгээр санал хураалтаа явуулмаар байна. Тэр дээд талын хүмүүс.

Ц.Сандаг-Очир: Б.Пүрэвдорж гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

19 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 52.6 хувиар санал дэмжигдлээ.

Үндсэн саналын томъёоллын уншиж танилцуулсан. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

19 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 52.6 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслөөр.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Хэн орсонгүй вэ? Э.Болормаа, О.Цогтгэрэл дарга. Уначихлаа. Дагасан хууль дээр.

О.Цогтгэрэл гишүүн горимын санал гаргая.

О.Цогтгэрэл: Саяын асуудал дээр миний санал бас эсрэг гарчихлаа. Тэгээд дахин санал хураалгаж өгөхийг хүсье.

Ц.Сандаг-Очир: О.Цогтгэрэл гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

10 гишүүн дэмжиж, 52.6 хувиар санал дэмжигдлээ.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж дууслаа. /алх цохив/

Үндсэн хоёр дахь санал хураалт.

Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 55 хувиар санал дэмжигдлээ.

Нийтээр тэмдэглэх баярын болон нэмэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг танилцуулна.

Гурав дахь асуудал хэлэлцэж дууслаа.

**Дөрөв.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл,
Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон
“Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай”**

Улсын Их Хурлын тогтоолын төсөл

/Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,

хоёр дахь хэлэлцүүлэг,

санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ./

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Засгийн газар 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хоёр дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Ням-Осорын Учрал Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Т.Доржханд Монгол Улсын Шадар сайд, Б.Жавхлан Сангийн сайд Д.Мөнх-Эрдэнэ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, А.Үйлстөгөлдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Б.Баасандорж Улсын Их Хурлын ерөнхий нарийн, Д.Баянбилэг Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга, Л.Цэдэвсүрэн Төрийн албаны зөвлөлийн дарга, Ж.Бямбасүрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Б.Цэнгэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Б.Лхагвасүрэн Улсын Их Хурлын Тамгын газрын Менежментийн газрын Санхүү, хангамжийн үйлчилгээний хэлтсийн дарга, Х.Отгонжаргал Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Санхүүгийн хэлтсийн дарга, Б.Бямбасүрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Д.Бат-Эрдэнэ Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга, Г.Ариунбуян Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал, Т.Мөнхдорж Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, ар талын газрын дарга, хурандаа, Т.Мөнх-Эрдэнэ Онцгой байдлын ерөнхий газрын Санхүүгийн хэлтсийн дарга, хошууч, Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Цогбадрах Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, С.Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Ж.Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч, Н.Мөнхсүх Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Л.Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Б.Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Н.Саруул Сангийн яамны Төрийн сангийн газрын Төлбөр, тооцооны хэлтсийн дарга,

М.Алтанхорол Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Д.Баттогтох Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга, О.Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Б.Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалтын төлөвлөлтийн хэлтсийн дарга, О.Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга.

Ажлын хэсэг танилцуулж дууслаа. /алх цохив/

Ажлын хэсэг бас дутуу байна.

С.Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, З.Цэдэнжав Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч, Ц.Наранчимэг Санхүү, нийцлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор, Д.Энхболд Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор, Б.Долгорсүрэн Санхүү, нийцлийн аудитын газрын аудитын менежер, Б.Лхагвацэнд Санхүү, нийцлийн аудитын газрын аудитын менежер, А.Цогбаяр Санхүү, нийцлийн аудитын газрын аудитын менежер, В.Эрдэнэцогт Санхүү, нийцлийн аудитын газрын аудитын менежер, И.Эрдэнэцэг Санхүү, нийцлийн аудитын газрын аудитын менежер, Ж.Бүжинханд Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор, П.Батцэцэг Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Б.Ариунжаргал Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Б.Долгоржав Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор, П.Амарсанаа Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор, С.Отгонхорлоо Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Т.Мягмаржав Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Ю.Энхтуяа Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын аудитын менежер, У.Оюунхүү Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын ахлах аудитор, Б.Идэрбалжинням Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын аудиторууд ирсэн байна.

Нэгдсэн төсвийн 2024 оны гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан танилцуулна.

С.Амарсайхан гишүүний микрофоныг өгье.

С.Амарсайхан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн

аудитын төв байгууллагаар аудит хийлгэн Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын чуулганы 06 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт танилцуулсан билээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2024 онд 29 их наяд 670.8 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 30 их наяд 591.1 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2 их наяд 451 тэрбум төгрөгөөр сайжирч, 920.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан ба сүүлийн 3 жил дараалан төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд тус Байнгын хороонд харьяалагдах Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Төрийн албаны зөвлөлийн дарга, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Монгол Улсын Шадар сайд, Монгол Улсын сайд, 20 минут хот Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны даргын багцын 196 төсөвт байгууллага, 4 төсөл, сан, төрийн өмчийн 10 аж ахуйн нэгж, нийт 210 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно.

Улсын төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 1 их наяд 327.8 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, үүнээс урсгал зардалд 937.7 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 390.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд тус Байнгын хороонд харьяалагдах 5 төсвийн ерөнхийлөн захирагчийн 66 төсөл, арга хэмжээнд 310.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, гүйцэтгэл 66.5 хувийн биелэлттэй байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгнө үү.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: С.Амарсайхан Шадар сайдад баярлалаа.

Одоо Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна.

Ажлын хэсгийн 6 номерын микрофоныг өгье.

С.Магнайсүрэн: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хууль болон Төсвийн тухай хуулийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын талаар тоймлон танилцуулъя.

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 4 тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллагыг аудитын түүвэрт хамрууллаа.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагын санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 0.3 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өглөө.

Өмнөх оны аудитаар өгсөн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглаж байгаа хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгэх, шинэчлэн тогтоох саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

2.Монгол Улсын Их Хурлын даргын төсвийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 2 төсвийн байгууллага, 1 төслийн санхүүгийн тайланг түүвэрт хамрууллаа.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 14.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 0.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 14.2 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

3. Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 30 тайлан нэгтгэснээс 25 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 5 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа 23 байгууллагад өөрчлөлтгүй, 2 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4.6 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 39.7 сая төгрөгийн зөрчилд 13 төлбөрийн акт, 1.5 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 38 албан шаардлага, 3 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 47 зөвлөмж өгсөн бөгөөд нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 51.9 тэрбум төгрөгийн 46 алдааг аудитын явцад залруулж ажиллалаа.

Өмнөх аудитаар өгсөн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд гарч буй эрсдэлд үнэлгээ хийж, эрсдэлд суурилсан дотоод аудитын төлөвлөгөө боловсруулж, илэрч буй алдаа, зөрчлийг 20 хувиар бууруулах талаар арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

4. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 15 тайлан нэгтгэснээс 5 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 10 байгууллагыг түүвэрт хамрууллаа.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа 4 байгууллагад өөрчлөлтгүй, 1 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1.5 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 35.7 сая төгрөгийн 8 зөрчилд төлбөрийн акт, 1 тэрбум төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 21 албан шаардлага, 0.3 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 14 зөвлөмж, 0.2 тэрбум төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн ба нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 2.2 тэрбум төгрөгийн 11 алдааг аудитын явцад залруулж ажиллалаа.

5. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2024 оны санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар 13.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 2.7 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 11.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн бөгөөд нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 36.6 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан.

6. Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэсэн 2 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчид хязгаарлалттай дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 0.5 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өгсөн бөгөөд нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 9 тэрбум төгрөгийн 3 алдааг аудитын явцад залрууллаа.

7. Төрийн албаны зөвлөлийн даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн 2 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 50.5 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч ажиллалаа.

8. Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны даргын төсвийн 2024 оны санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 50 тэрбум төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, зөрчлийг таслан зогсох 1 албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

Өмнөх оны аудитаар өгсөн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг боловсруулахдаа хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээтэй уялдуулан боловсруулах зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай байна.

Дээр дурдсан аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах асуудлуудад анхаарлаа хандуулахыг санал болгож байгаа. Үүнд:

➤ **Нэг.** Төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүн, чанар, тоо хэмжээг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан хяналт шинжилгээ, үнэлгээ хийж баталгаажуулах.

➤ **Хоёр.** Төсвийг зохистой удирдаагүйгээс авлага, өр төлбөр үүсгэсэн тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, эзэн холбогч тодорхойгүй, хугацаа хэтэрсэн, найдваргүй болох эрсдэлтэй авлагыг барагдуулах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх.

➤ **Гурав.**Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн зарцуулалт, худалдан авах, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа дахь эрсдэлийг бууруулж, дотоод аудитыг хийж гүйцэтгэх нь.

➤ **Дөрөв.**Төсвийн ерөнхийлөн захирагчид худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах.

➤ **Тав.**Аудитор тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарах.

Танилцуулж дууслаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Монгол Улсын Ерөнхий аудиторт баярлалаа.

Одоо Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх Сангийн сайдын танилцуулга болон аудитын тайлан, Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү?

Ж.Баярмаа гишүүнээр тасаллаа. Э.Болормаа гишүүн асуултаа асууя.

Э.Болормаа: Ингээд 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын манай Байнгын хорооны эрхлэх асуудал дундаас нэг зүйлийг тодруулах гэсэн юм.

Энэ дунд “0” хувийн гүйцэтгэлтэй 5 хөрөнгө оруулалт байна л даа.

Тэгэхээр энэ яагаад “0” хувийн гүйцэтгэлтэй байгаа вэ гэдгийг тодруулах гэсэн юм.

Онцолж хэлэх юм бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын доор Засгийн газрын нэг цэгийн үйлчилгээний цогцолборын зураг төсөв, барилга угсралтын ажил “0” хувийн гүйцэтгэлтэй. 2024 онд.

Түүний дараа болохоор Архангай аймгийн Цахир сумын иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга мөн “0” хувийн гүйцэтгэлтэй.

Архангай аймгийн Өндөр-Улаан сумын иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга “0” хувийн гүйцэтгэлтэй.

Мөн Хөвсгөл аймгийн Галт сумын иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн байр “0” хувийн гүйцэтгэлтэй.

Тэгээд хамгийн сүүлд 20 минутын хот Үндэсний хорооны дарга энэ түгжрэлийг бууруулах, хотын төвлөрлийг сааруулах асуудлын хүрээнд захиргааны зарим байгууллагын нэгдсэн цогцолбор барилгын дуусгал гэж мөн “0” хувийн гүйцэтгэлтэй. Нийт 45 тэрбум төгрөгийн ийм зардлууд байна.

Тэгэхээр эхлээд энэ 5 хөрөнгө оруулалт манай Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд яагаад “0” хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнтэй холбоотойгоор Сангийн сайдаас эдгээр нь 0 хувийн гүйцэтгэлтэй учир 2025 оны төсвийн тодотгол бид хийж байгаа. Энэ таналтад орж ирж байгаа юу гэдгийг асууя.

Ц.Сандаг-Очир: Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 2 номер.

Ж.Дэлгэржаргал: Э.Болормаа гишүүний асуултад ярья.

Сангийн яам. Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар.
Ж.Дэлгэржаргал.

Тэгэхээр 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1319 төслийг хэрэгжүүлсэн. Эдгээрийн 712 нь 2024 онд шинээр эхэлсэн төслүүд байгаа. Энэ дотор 212, 712 төслийн 270 нь Улсын Их Хурал дээр хэлэлцүүлгийн явцад шинээр нэмэгдсэн.

Тэгэхээр 2024 оны гүйцэтгэлийн хувьд бид 3.8 их наядын 3 их наядыг яг санхүүжилт гүйцэтгэлээр олгож 80 хувьтай гарсан.

Тэгэхээр үлдэгдэл олгоогүй 760 тэрбум дотор 90 төслийн санхүүжилт гэрээ байгуулаагүй байгаа.

Тэгэхээр таны саяын хэлсэн төслүүд 2024 оныхоо төсвийн жилд багтаж гэрээ байгуулаагүй учраас улсын төсөвтөө буцаад төвлөрсөн. Энэ гэрээ байгуулаагүй төслүүдийн хувьд хэрвээ 2026 он дээр үргэлжлэх шаардлагатай гэж үзвэл төсвийн ерөнхийлөн захирагчийн саналаар 2026 оны төсвийн төсөл дээр бид үргэлжлүүлээд хэрэгжүүлнэ, тусгана.

Ц.Сандаг-Очир: Болсон уу? Тодруулах уу?

Э.Болормаа гишүүн тодруулъя.

Э.Болормаа: 2026 он биш. Би 2025 оны төсвийн тодотгол дээр энэ гэрээ байгуулагдаагүй бол хасагдаж байгаа гэсэн ийм ерөнхий мэдээлэл өгсөн учир эд нар бүгдээрээ, энэ 5 төсөл 2024 онд гэрээгээ байгуулаагүй юм байна гэж ойлголоо.

Тэгэхээр энэ 2025 оны төсвийн тодотголд орж байгаа юу?

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 2 дахь микрофон.

Ж.Дэлгэржаргал: 5 төслийн Засгийн газрын нэг цэгийн үйлчилгээний барилга 2024 оны төсөвт тодотголоор анх батлагдаад нууц руу орсон.

2025 оны тодотгол дээр гэрээ байгуулаагүй учраас 210 тэрбум нь хэмнэлтэд орсон.

Түгжрэлийг бууруулах барилга байгууламж нийслэлийн Яармаг дахь шинэ захиргааны байр байгаа. Үүнтэй холбоотой 45 тэрбум энэ онд гэрээ хийсэн учраас төсвийн тодотгол дээр хасагдаагүй. Тусгагдаж байгаа.

Орон нутгийн 3 иргэдэд үйлчлэх мэдээллийн төв буюу Тамгын газрын хувьд 2025 ондоо гэрээ хийсэн учраас энэ тодотголоор хэмнэгдээгүй үргэлжлээд хэрэгжихээр төсвийн төсөлд тусгагдсан байгаа. Тодотголын.

Ц.Сандаг-Очир: Ж.Баярмаа гишүүн асуултаа асууя.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье.

Энэ иргэдийн дунд төдийгүй бид нарын хувьд ч гэсэн нэг маргаантай асуудал гараад байгаа юм л даа. Жишээлбэл, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайланд болохоор санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүгнэлтээр гээд нөгөө 2024 оны алдаа, зөрчил гэхээр 15.7 их наяд буюу өмнөх оныхоос 48 хувь буюу бараг 50 хувиар их байна гэж гараад байгаа юм.

Тэгэхээр энэ үнэн юм уу?

Тэгэнгүүт танай аудитын дүгнэлт дотор, тэр сүүлийн хуудас хавьцаа нийт алдаа, зөрчлийн дүн 9.3 их наяд байна гээд байгаа юм.

Тэгэхээр энэ хоёрын хооронд зөрүү асар их л дээ.

Тэгэхээр аль нь ямар тооцоолол болоод ингээд хоёр өөр зөрүүтэй тоо гараад байгаа юм бол гэдгийг нэгдүгээрт тайлбарлаад өгөөч ээ.

Хоёрдугаарт, сая Э.Болормаа гишүүн асууж байна л даа. Нөгөө иргэдийн мэдээллийн төв гээд. Ноднин 8 сард хийсэн тодотголоор иргэдийн мэдээллийн төв, соёлын төв зэргийг гайхаж бид хүлээж авсан л даа. Энэ ямар ач холбогдолтой юм бол, яг юу хийдэг юм бол гээд. Тэгээд түүнээсээ улбаалаад бараг л аймгуудад сайн дураараа очиж бас судалсан л даа. Ямар хэрэгтэй юм гэхээр тэр ямар ч хэрэггүй ээ. Манайд бүх байшин байна гээд. Тэр бүү хэл зарим сумдад бүр энэ төрийн байгууллагын байшин, барилга нь ихэдсэн. Бүр 3, 4 ширхэг тийм шинэ байшингууд бий болсон гэж байгаа юм.

Тэгээд иргэдэд мэдээлэл өгөх төвийн байр ерөөсөө хэрэггүй гээд байгаа юм. Тэр үед асууж байхад аль 2024 оны төсөвт орсон юм. Тодотгол биш. Өмнө

нь байсан юм. Үүнийг ерөөсөө хөндөж болохгүй. Ямар ч асуудалгүй. Та нар бүү хөнд. Та нараас өмнөх асуудал гээд л Б.Жавхлан сайд загнасан л даа.

Тэгээд одоо ингээд сонсож байхад гүйцэтгэл нь “0” гээд байна.

Тэгэхээр баригддаггүй ийм хэдэн байшин байх шаардлагатай ч юм уу, үгүй ч юм уу. Уг нь Б.Жавхлан сайд байсан бол. Яана аа. Уучлаарай. Таныг тэнд суусан юм болов уу. Үгүй үгүй, би таныг байхад ч гэсэн загнадаг шүү дээ. Энэ иргэдэд мэдээлэл өгөх төвүүд чинь одоо ямар учиртай юм бэ? Чухамхүү хэрэгтэй л гэдэг. Гэтэл гүйцэтгэл нь “0”.

Тэгэхээр энэ чигт нь сайхан царцаагаад бүр больчихвол яасан юм. Төсвөө хэмнэх гэж та чинь ёстой махаа идэж байгаа биз дээ?

Тэгэхээр үнэнтэйгээ нүүр тулаад энэ хэдэн иргэдэд мэдээлэл өгөх төв гээд. Энэ чинь бас багагүй. 3-аас 5 тэрбумын өртөгтэй байшингуудаа бүр болиод ингээд бүр мартаад ингэвэл яасан юм?

Тэгээд тэр зөрүү. Хоёр мөнгөн дүнгийн алдаа зөрчлийн зөрүү. 15.7 их наяд гэдэг чинь төсвийнхөө тал нь шахам алдаатай, зөрчилтэй гээд явж байвал энэ чинь одоо Монгол Улс чинь бараг энэ төсвийн хариуцлага, санхүүгийн хариуцлага бүр сүйрчихсэн юм биш үү гэж харагдахуйц байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр нэг тайлбар хэлээд өгөөч. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Ж.Баярмаа гишүүний асуултад ажлын хэсгийн 6 номерын микрофон. Хэн бэ? Хэдэн номер вэ? 7 юу? 7 номерын микрофон.

Нэр усаа хэлээд хариулаарай.

Ц.Наранчимэг: Ж.Баярмаа гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар. Ц.Наранчимэг.

Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд 6832 төсөв захирагчийн 61 төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны байгууллагуудад аудит хийж дүгнэлт гаргаж байгаа.

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай санал, дүгнэлтийг өгсөн.

Энэ хязгаарлалттай санал, дүгнэлтийн үндэслэл маань 9.3 их наяд төгрөгийн зөрчил байна гэсэн ийм асуудал байгаа.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гаргасан 15.4 их наяд төгрөгийг манай тайлан дээр байгаа нийцлийн асуудлаар илэрсэн зөрчил, санхүүгийн

тайлангийн аудитаар илэрсэн зөрчил хоёрыг нийлүүлээд дүгнэсэн юм байна гэж бид ойлгосон.

Нийцлийн асуудал гэдэг дээр ямар асуудлууд байдаг вэ гэхээр жишээлбэл шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хугацаандаа шилэн дансны хуулиа хэрэгжүүлээгүй, мэдээллээ байршуулаагүй бол мөнгөн дүнтэй нь энэ асуудлыг бичдэг. Тэдэн сая, тэдэн тэрбум төгрөгийн тэдэн мэдээллийг хуулийн хугацаанд байршуулаагүй байна гэсэн.

Тэгэхээр энэ дүнгүүдийг нийлүүлээд тавьчихаар энэ асуудал.

Яг илэрсэн зөрчил бол 9.2 их наяд буюу 5 их наяд нь Улсын Их Хурлын нэгдсэн чуулган дээр Та асуугаад би хариулсан. Бүртгэл, тайлагналтай холбоотой 5 их наяд байгаа. Үлдсэн нь энэ 6832 төсвийн захирагчийн санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гаргахад илэрсэн зөрчил байна.

Ц.Сандаг-Очир: Тодруулах уу? Болсон уу?

Гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Одоо үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Э.Болормаа гишүүнээр тасаллаа. Э.Болормаа гишүүний микрофоныг өгье.

Э.Болормаа: Одоо бид жил болгон төсвийн гүйцэтгэл хэлэлцдэг. Аймаг, орон нутагт, эсвэл төрийн байгууллагууд ер жил хаах гээд эхлэхээр тэнд тэдэн төгрөг үлдсэн байна, энд тэдэн төгрөг үлдсэн байна. Хурдхан шиг үүнийгээ хэрэглээдэхье. Энэ дээр нэмээд ийм юм аваадах гэдэг ч юм уу ийм хандлага анзаарагддаг.

Тэгээд нөгөө бүх төсөвлөсөн төсвөө хэрэглэхээр 100 хувийн гүйцэтгэлтэй гэж эергээр сайн гэж харагддаг.

Тэгээд нэгэнт энэ Засгийн газар маш төвөгтэй нөхцөл дунд хэмнэлтийн горим руу шилжиж, төсвийн тодотгол хийж байгаа энэ үед ер нь бид энэ тогтолцоогоо цаашдаа байнгын зөв чиглүүлэх, зөв хэмнэлт рүү явуулах тийм байдал руу шилжүүлбэл яасан юм бэ гэсэн ийм саналтай байна.

Тэгээд үүнийг цаашид манай сангийн яамныхан холбогдох журмууддаа анхаараад, магадгүй оны эцэст гэхэд тодорхой хэмжээний урсгал зардал дээрээ хэмнэлт гаргах юм бол энэ нь сайн гэж харагддаг. Түүнээс биш оны эцэс гэхэд нөгөө төсөвлөсөн бүх мөнгөө заавал үрж дуусгаж байж тэр нь 100 хувийн гүйцэтгэлтэй эерэг гэж харагддаг гэж үзэхээс илүүтэйгээр яг л нөгөө ажлыг нь дүгнэж байгаа байдал нь, бүтээмжээр нь, хийгдсэн зүйлсээр нь илүү хараасай гэж бодож байна.

Тэгэхээр цаашид нэгэнт бид хэмнэлт ярьж байгаа ийм үед илүү яаж, жил болгон зөвхөн нэг удаагийн төсвийг харах биш, ер нь жил болгон тодотгоод байхгүйгээр өөрсдөө байгууллагууд дотооддоо хэмнэлт хийхийг нь зөв эергээр урамшуулах тийм тогтолцоо руу бас оруулбал зүйтэй болов уу гэсэн ийм саналыг хэлье.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Би нэг санал хэлье.

Аудитынхан маань энэ санхүүгийн алдаа, зөрчил дутагдлууд юмнуудаа бас ялгаж салгаж олон нийтэд зөв ойлгуулах тал дээрээ хэлэхгүй бол нэг л их 9 аравны хэдэн их наяд төгрөгийн алдаа, зөрчил дутагдал гээд яриад байгаа. Энэ дотор чинь нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа зөрчил. Одоо тэгээд эд нар чинь залруулагдаад явдаг шүү дээ. Энэ юмнуудыг нарийн сайн. Дийлэнх олонх нь ийм байгаа юм.

Тэгээд энэ болгоны ялгаа заагийг сайн олон нийтэд гаргахгүй бол. Тэгэхгүй бол одоо нэг л их төсвийн ерөнхийлөн захирагч нар татвар төлөгчдийн мөнгийг санхүүгийн сахилга батгүй, идэж уусан, алдаа зөрчил гаргадаг юм байна гэдэг ийм буруу ойлголт гарах, ойлгох ийм асуудлууд байна шүү.

Тийм учраас энэ алдаа зөрчил дутагдлуудын аль нь хэдэн тэрбум төгрөг нь, хэдэн зөрчил дутагдал нь энэ нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн бүртгэл хөтлөлттэй холбоотойгоор залруулагддаг алдаа дутагдлууд байгаа юм бэ.

Яг цаана нь бас төсвийн албан тушаалаа хэтрүүлсэн, эрх мэдлээ урвуулан ашигласан, гэмт хэргийн шинжтэй байж болох ийм асуудлууд нь хэд байгаа юм гэдэг юмнуудыг нарийн сайн ялгаа заагийг нь гаргаж, цаашдаа энэ тайлан юман дээрээ тусгаж, ярьж хэлж байхгүй бол, гишүүдийн асуултад хэлж байхгүй бол нэг л их төрийн байгууллагын дарга нар төсвийн татвар төлөгчдийн мөнгийг үргүй зарцуулж байгаа юм шиг, их наядаар хэмжигдэх хэмжээний алдаа, зөрчил дутагдал гарсан байна шүү дээ гэж олон нийтэд ойлгогдох буруу ташаа ойлголтууд яваад байна шүү. Энэ дээрээ та бүхэн дараа дараагийн хэлэлцүүлгийн үе шатад зөв тайлбарлаж, ялгаа заагийг нь зөв хэлээрэй.

Хэдэн акт, хэдэн албан шаардлага хүргүүлсэн юм. Энэ юмнуудаа бас ялгаа заагийг нь тодорхой гаргаж хэлээрэй гэдгийг хэлье.

Ингээд Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа танилцуулна.

Дөрөв дэх асуудал хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудалдаа оръё.

**Тав.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,
Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,
Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хоёр дахь хэлэлцүүлэг,
санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./**

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн танилцуулгыг Монгол Улсын Сангийн сайд Б.Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Дэлхий дахинд үүсээд буй сорилт, бэрхшээлийн Монгол Улсын эдийн засаг, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, мөн Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2, 34.1.4 дэх заалтын дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголын төслийг боловсруулж, 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Эдийн засгийн сорилт, хүндрэлийг даван туулахад төсвийн сахилга бат, үр ашигтай зарцуулалт онцгой чухал үүрэгтэй. Тиймээс хэмнэлтийн тодотголд бүх шатын төрийн байгууллагуудын тэвчиж болох зардлыг хэмнэх зарчмыг баримталлаа.

Энэ хүрээнд бүх шатын төрийн байгууллагуудын тэвчих болох зардал, бүх хөтөлбөр, арга хэмжээг зогсооно. Үүнд:

Цомхон бүтээмжтэй төртэй байхын тулд төрийн албаны орон тоог 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлэн 9 хувиар бууруулахаар тооцлоо.

Мөн төсөвт байгууллагын тээвэр шатахуун, дотоод албан томилолт, хичээл, үйлдвэрлэлийн зардал, төрийн өндөр дээд айлчлал болон өндөр түвшний зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албан томилолт зочин төлөөлөгч хүлээн авах зардал, тавилга, эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх болон багаж техникийн зардал, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад олгодог татаасын зардал, байгууллагаас олгох нэг удаагийн болон бусад төрлийн тэтгэмж, урамшуулал, хөтөлбөр, арга хэмжээний зардал зэргийг хэмнэхээр тооцож, холбогдох өөрчлөлтийг тодотголын төсөлд тусгалаа.

Ингэснээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын багцын төсөв 2025 оны батлагдсан төсвийн урсгал зардлыг 4.2 тэрбум төгрөг, хөрөнгийн зардлыг 305 сая төгрөг, нийт зардлыг 4.5 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн.

Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын багцын хэмжээнд төрийн албан хаагчийн ор тоог 9 хувиар буюу 19 орон тоо буурч, 380 орон тоотой байхаар тооцлоо.

Монгол Улсын Их Хурлын дарга 2025 оны батлагдсан төсвөөс урсгал зардлыг 8.2 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн.

Багцын хэмжээнд 126 орон тоо буурч, 934 орон тоотой байхаар тооцлоо.

Улсын Их Хурлын Тамгын газрын даргын багц дахь Улсын Их Хурлын гишүүдийн төсөв, Байнгын хороодын үйл ажиллагааны зардал, Улсын Их Хурал дахь намын бүлгийн үйл ажиллагааны зардлыг тус тус бууруулаагүй тооцлоо.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга 2025 оны батлагдсан төсвөөс нийт зардлыг 40.8 тэрбум төгрөг, хөрөнгийн зардлыг 1.1 сая төгрөг, нийт зардлыг 41.9 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн.

Сайдын багцын хэмжээнд төрийн албан хаагчийн тоог 50 орон тоо буурч, 537 орон тоотой байхаар тооцлоо.

Монгол Улсын Ерөнхий сайд төрийн чиг үүргийг оновчтой зохион байгуулж, цомхон, чадварлаг бүтцээр ажиллах зорилт тавьж, зарим сайдын чиг үүргийг ойролцоо чиг үүрэг эрхэлдэг, мөн өмнө нь харьяалж байсан эрхэлдэг асуудлын хүрээнд харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бусад сайдын эрхлэх асуудалд шилжүүлэх болсонтой холбогдуулан төсвийн тодотголын төсөлд зарим өөрчлөлтийг тусгалаа. Тухайлбал, хилийн бүс дэх тээвэр ложистикийн нэгдсэн сүлжээг хөгжүүлэх, хилийн боомтын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг өмнө нь байсан чиг үүргийн дагуу Сангийн сайдын чиг үүрэгт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын чиг үүрэгт, 20

минутын хотын хөгжлийн асуудлыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын чиг үүрэгт тус тус шилжүүлж, холбогдох төсвийн өөрчлөлтийг тусгалаа.

Чиг үүргийн өөрчлөлттэй холбогдуулан Монгол Улсын сайд, Хяналт шалгалт, үнэлгээний Үндэсний хорооны даргын алба, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын ажлын алба, Монгол Улсын сайд, 20 минут тоот Үндэсний хорооны даргын ажлын албыг тус тус татан буулгахаар тооцсон зардлыг бууруулан тооцлоо.

Үндсэн хуулийн цэцийн даргын багцын 2025 оны батлагдсан төсвөөс урсгал зардлыг 500 сая төгрөг, нийт зардлыг мөн 500 сая төгрөгөөр бууруулахаар төлөвлөлөө.

Тус салбарын төрийн албан хаагчийн тоог 9 хувиар буюу 5 орон тоо буурч, 56 орон тоотой байхаар тооцлоо.

Шадар сайдын багцын 2025 оны батлагдсан төсвөөс хөрөнгийн зардлыг 5.9 тэрбум төгрөгөөр, урсгаж зардлыг 26.3 тэрбум төгрөгөөр буюу 32.2 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн нь нийт зардлын 8.3 хувь байна.

Салбарын төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхтэй холбогдуулан тус салбарын цалингийн санг 10.8 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн.

Харин сайдын эрхлэх асуудлын тусгай чиг үүргийн байгууллагуудаас тусгай чиг үүргийн байгууллагуудаас тээвэр, шатахуун, дотоод томилолт, нормын хувцас, эрдэм шинжилгээ, судалгаа, байгалийн гамшиг ослын үр дагаврыг арилгах зардлуудыг бууруулахгүйгээр төлөвлөж тусгасан.

Төрийн албаны зөвлөлийн даргын багцын төсөв 2025 оны батлагдсан төсвөөс нийт зардлыг 4.3 тэрбум төгрөгөөр бууруулахаар төлөвлөлөө.

Тус салбарын төрийн албан хаагчийн тоог 9 хувиар буюу 7 орон тоо буурч, 78 орон тоотой байхаар тооцлоо.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын багцын төсвийг 2025 оныг баталсан нийт төсвөөс зардлыг 900 сая төгрөгөөр бууруулахаар төлөвлөсөн.

Тус салбарын төрийн албан хаагчийн тоог 9 хувиар буюу 4 орон тоо буурч, 43 орон тоотой байхаар тооцлоо.

Ийнхүү 2025 оны төсөвт тодотгол хийснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 3 их наяд 260 тэрбум төгрөгөөр бууруулж, 30 их наяд 209 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зардлыг хэмжээг хэмжээг 1 их наяд 856 тэрбум төгрөгөөр бууруулж, 31 их наяд 575 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн

төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 365.2 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүн 1.5 хувийн алдагдалтай болж байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Сангийн сайдад баярлалаа.

Одоо Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаар Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн дарга танилцуулна.

Ажлын хэсгийн 6 дахь микрофоныг өгье.

С.Магнайсүрэн: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах 8 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт 1.2 тэрбум төгрөгөөр, зарлагыг 302.4 тэрбум төгрөгөөр тус тус бууруулахаар төлөвлөжээ.

Байнгын хороо энэхүү төслийг хэлэлцэн шийдвэрлэхдээ дараах асуудалд анхаарал хандуулахыг санал болгож байна. Үүнд:

1.Уул уурхайн салбарын орлого гадаад зах зээлийн нөхцөл байдлаас хамаарч тодорхой бус эрсдэлтэй байгаа учир уул уурхайн бус орлогын

боломжит эх үүсвэрийг бүрэн дайчлах, татварын хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах, хураалт үйлчилгээг сайжруулах.

2.Төрийн албан хаагчдын орон тоог чиг үүргийн давхардал, ажлын байрны ачаалалд бүрэн шинжилгээ хийлгүйгээр нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарын харьяа орон тоог жигд 9 хувиар бууруулахаар тооцсон нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлж болзошгүй. Иймд төсвийн ерөнхийлөн захирагчдад өөрийн хариуцсан салбартаа чиг үүргийн шинжилгээ, ажлын байрны ба бүтээмжийн үнэлгээг хийсний үндсэн дээр ажлын ачааллыг оновчтой хуваарилах зорилгоор харьяа байгууллагуудынхаа орон тоонд зохицуулалт хийх боломжийг олгох асуудлыг судалж үзэх.

3.Төсвийн тодотголтой хамт Улсын Их Хуралд өргөн барьсан тогтоолын төсөлд 2025, 2026 оны төсвийн төсөлд өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх, шинээр ажлын чиг үүрэг, албан тушаалын орон тоо бий болгохгүй байх, ажлын байрны ачааллыг нягтруулах зэргээр цалин хөлсний зардлыг хэмнэх гэж заасан.

Энэ нь чиг үүргийн судалгаа хийсний үндсэн дээр ажлын ачааллыг нягтруулж, орон тоогоо зорилтот түвшин хүртэл нэгэнт бууруулсан байгууллагуудад сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх нь тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болгох нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байгааг анхаарч үзэх.

4.Төсвийн ерөнхийлөн захирагч нарын сул орон тооноос бусад цомхотголд орж буй албан хаагчдад Төрийн албаны тухай хуулийн дагуу ажлаас чөлөөлсний нэг удаагийн тэтгэмжийн зардал шаардагдаж байгааг энэ хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад хамтад нь шийдвэрлэх гарц шийдлийг олох шаардлагатай байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэснээ үүгээр танилцуулж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Монгол Улсын Ерөнхий аудиторт баярлалаа.

Одоо хуулийн төслүүдийн талаарх Сангийн сайдын танилцуулга болон аудитын дүгнэлт, Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү.

Б.Баярбаатар гишүүнээр тасаллаа. Б.Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн мөнгөнөөс одоо энэ сайд байгаа дээр асууя гэж бодоод.

“Орон нутгийн хөгжлийн сан”-гаас хамгийн өндөр нь Ховд аймгаас хасаад хаячихсан байх юм. Тэгээд энэ хувиар тооцсон гээд тэгэхээр бусад аймгуудаас тийм өндөр байдаг юм уу? 12 тэрбум төгрөг “Орон нутгийн хөгжлийн сан”-гаас Ховд аймгийнхыг хассан байх юм.

Бусад аймгууд чинь 4, 5 л байгаад байгаа юм. Тэгээд хувиар хассан гээд тэгээд байх юм.

“Орон нутгийн хөгжлийн сан” чинь зөвхөн Сангийн яамнаас, улсын төсвөөс бас энэ “Орон нутгийн хөгжлийн сан”-д тодорхой хэмжээний мөнгө өгдөг. Гэхдээ манай Ховд аймаг өөрөө Хөшөөтийн **МОНЭНКО** /Mongolia Energy Corporation Limited/ компаниас тонн нүүрс тутамд нэг доллар аваад, түүнийгээ “Орон нутгийн хөгжлийн сан”-д оруулдаг. Энэ жил 10 тэрбум төгрөг оруулсан. Өнгөрсөн жил. Энэ жил одоо бас дахиад л оруулаад явж байгаа.

Тэгээд тэр мөнгийг маань аваад явчихсан байх юм. Зөвхөн Улаанбаатар хотоос, Сангийн яамнаас, улсын төсвөөс өгдөг юм биш шүү дээ.

Тийм учраас энэ дээр яагаад ингээд хассан юм? Бүх “Орон нутгийн хөгжлийн сан” улсын төсвөөс болон МОНЭНКО-оос орж байгаа.

Тэгэхдээ энэ хоёрын харьцаагаараа бас багасгах боломж юу байна? Түүнийгээ хэлж өгөөч.

Ц.Сандаг-Очир: Б.Пүрэвдорж гишүүний асуултад сайд хариулах уу? Сангийн сайд хариулах уу? Хэн хариулах юм? Ажлын хэсгийн 3 номерын микрофон. Нэр, албан тушаалаа хэлээрэй.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. Б.Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя.

Энэ жилийн анхны батлагдсан төсөв дээр “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн төсөв 599.0 тэрбум төгрөг болсон. 600 орчим гэсэн үг.

Энэ дүн маань АМНАТ-ийн орлого буурч байгаатай холбоотойгоор АМНАТ-ийн орлогын төлөвлөгөөг бид 5.6 их наяд гэж тавьсан байсныг тодотголоор 3.9 их наяд болгож 1.7 их наяд төгрөгөөр бууруулсан байгаа.

АМНАТ-ийн орлогын 10 хувь нь өөрөө энэ “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн эх үүсвэр болдог. Үүнтэй холбоотойгоор ерөөсөө энэ дээр томъёогоороо эх үүсвэрийн томъёо нь орж ирээд тэгээд нийтдээ 182 тэрбум төгрөг буурсан байгаа.

Аймгуудын хувьд ч гэсэн дунджаар ижилхэн 30 хувиар бүх аймаг дээр ижилхэн буурсан байгаа.

Ер нь Ховд аймгийн хувьд бусад аймгуудаас ялгаатай нь Дорноговь, Ховд аймгийн хувьд тухайн аймагтаа байгаа орон нутгийн тэр орон нутагт нь үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудаас бас хандив, тусламж авдаг юм билээ. Энэ орлого нь бас энэ санд ордог. Энэ сан дээр одоо тэр орлоготой холбоотой хэсгүүд бас давхар нөлөөлж орж ирж байгаа.

Түүнээс биш улсын төсвөөс “Орон нутгийн хөгжлийн сан” дээр ямар нэгэн төлбөр өгдөггүй.

“Орон нутгийн хөгжлийн сан” шууд орлогуудаар, эх үүсвэрээр нь хуваарилсан хуультай байгаа. Жишээ нь,

- ▶ хайгуулын тусгай зөвшөөрөл,
- ▶ ашиглалтын тусгай зөвшөөрөл,
- ▶ лицензийн төлбөрүүд

“Орон нутгийн хөгжлийн сан”-даа байна.

Энэ нь тухайн аймаг дээрээ хэр их лиценз, уул уурхай дэмжиж байна тэр хэмжээгээр нэмэгдэж байгаа гэсэн үг.

АМНАТ-ийн 10 хувийн хуваарилалт үндсэндээ 3 гол үндсэн үзүүлэлтээс хамаарч байгаа.

- ▶ Газар нутгийн хэмжээ,
- ▶ Хүн амын тоо гэх мэт.

Тэгш хуваах зарчмаар хуваарилж байгаа.

Түүнээс биш яг Ховд аймаг дээр тусгайлан өөр байдлаар өөр тийм томъёо байхгүй. Эх үүсвэрийн хувьд бүгд ижил явж байгаа.

Нөгөө талдаа түрүүний Байнгын хороон дээр бас санал гарч байсан. Жишээ нь, “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн төсвийг хасахгүйгээр өгвөл яах юм бэ гэдэг ийм санал гарч байсан. Хэрвээ хасахгүйгээр орох юм бол энэ дээр нөгөө эх үүсвэр маань байхгүй учраас төсвийн тоо харагдаад байна. Тэгэхдээ орлого нь орж ирэхгүй л гэсэн ийм юм болно гэсэн үг.

Нөгөө талдаа өөрөө нөгөө АМНАТ-ийн хэмжээ буурч байгаатай холбоотойгоор томьёо нь бас ингэж бодогдож орж ирэх ёстой болно гэсэн ийм санаа гарч ирж байгаа.

Мэдээж хэрэг аймгуудын хувьд хүндрэлтэй асуудал гарч ирнэ. Оны эхэнд гэрээгээ “Орон нутгийн хөгжлийн сан”-гаар байгуулсан гэрээнүүд байгаа. Үүнийгээ яах вэ гэдэг асуудал гарч ирнэ.

Өмнө нь бас яг ийм “Орон нутгийн хөгжлийн сан”-тай холбоотой огцом буурч байсан жилүүд гарч байсан. Тэр үед ямар арга хэмжээ авч байсан гэхээр дараа жилийн төсөв дээрээсээ “Орон нутгийн хөгжлийн сан” дээрээсээ үлдэгдэл төлбөрөө төлөөд явж байсан ийм практик байдаг. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Болсон уу? Б.Баярбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Баярбаатар: Өчигдөр манай Ёс зүй, дэгийн байнгын хорооны хурал хуралдаж хамрах хүрээнийхээ асуудлыг хэлэлцсэн юм.

Энэ дээр Б.Жавхлан сайд Сангийн сайд бас байсан. Тэгээд Төрийн албаны зөвлөл дээрээс гишүүд нэлээдгүй асуусан юм. Тэр бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж гээд 2.7-г нь тануулаад, одоо 3.3 үлдсэн төсөв байгаа.

Энэ дээр Төрийн албаны зөвлөлийн дарга тодорхой ойлголт өгөөд бас нэг хариулах нь зөв болов уу гэж бодож байна. Нэг.

Хоёрт, ер нь дараа дараагийн төсөв дээр орж ирэхдээ бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ гэдгээ ер нь задалж оруулж ирсэн нь дээр байх. Ард нь асар том тоо тавьдаг.

Тэгээд сая төсвийн гүйцэтгэл дээр ч гэсэн ажиглаад байхад. Одоо ингээд төсөв хэлэлцэх болохоор л удирдлагууд, салбар салбарынхан, тэгээд Улсын Их Хурлын гишүүд дээр ирээд л манай төсөв дээр ийм юм тавиулаад өгөөч, тэрийг дэмжээд өгөөч, үүнийг оруулаад өгөөч гээд л гуйгаад явдаг байхгүй юу.

Тэгээд нөгөөхийг нь дэмжээд оруулаад батлаад өгдөг. Дараа жил нь гүйцэтгэл хэлэлцэх болохоор мөнгөө хэрэглэж чадаагүй буцаагаад баахан татуулж байгаа юм. Тэгээд иймэрхүү байдлаар цаашдаа хандмааргүй байгаа юм.

Яг л тэр гарах ёстой зардал, тэр шаардлагатай урсгал зардал, хөрөнгө оруулалт гэдэг зүйл дээрээ л төвлөрөхгүй бол. Манай монголчуудын зан юм уу. Аль болох л ахиухан тавьж байж л сэтгэл санаа нь амрах гээд байдаг.

Тэгэхээр энэ дээр ер нь дараа дараагийн төсөв дээрээ анхаармаар байна. Тэр бусдаар гүйцэтгэх ажил, үйлчилгээ гэж ер нь тийм томъёолол ер нь ирэх жилийн төсөв дээр битгий орж ирээсэй гэж бодож байгаа. Сайхан задлаад орж ирэх ёстой.

Энэ нь өөрөө цаанаасаа Улсын Их Хурлын гишүүдийн анхаарлыг татаад, бас тодорхой түвшний хардлага төрүүлээд. Тэгээд тэр нь нэлээдгүй бас өндөр тоонууд. Яг тэр дотроо харахаар нэлээдгүй өндөр тоонууд л байгаад байгаа байхгүй юу. Одоо жишээлбэл, бусад зардлууд, энэ аудит, даатгал, тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо, мэдээлэл технологи, улсын мэдээллийн маягт хэвлэх гээд. Эд нар нь бас л бусдаар гүйцэтгүүлэх ажил шүү дээ. Ер нь бол.

Тэгсэн мөртлөө эд нар нь ингээд тусдаа задарчихсан байж байгаа. Гэтэл дээр нь ерөнхий байдлаар бусдаар гүйцэтгүүлсэн ажил гээд ийм байгаа. Энэ дээр нэг хариулт авъя. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Б.Баярбаатар гишүүний асуултад ажлын хэсгийн 1 номерын микрофон. Төрийн албаны зөвлөл эхлээд хариулъя.

Л.Цэдэвсүрэн: Б.Баярбаатар гишүүний асуултад хариулъя.

Төрийн албаны зөвлөлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо гэсэн хоёр байгууллагын төсөв нийлбэр дүнгээрээ орж ирдэг.

2025 оны төсөв маань 19.4 тэрбумаар батлагдсан.

Яг саяын хэлээд байгаа энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ гэдгийн дээд талд нь “төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх болон нийтлэг үйлчилгээ” гэсэн ийм ангилал байгаа юм.

Тэгээд “бусдаар гүйцэтгүүлэх” гэхээр бүгдийг нь хүнээр хийлгэх юм шиг ойлгоод байгаа юм. Энэ дотор нь манай үндсэн үйл ажиллагааны зардлууд бас байдаг.

Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт, хүний нөөцийн аудит хийх, ялангуяа төрийн албан хаагчдын сонгон шалгаруулалтын тест болон мэдээллийн сангийн баяжилтыг хийх, төрийн албаны ерөнхий шалгалтыг зохион байгуулах ажлуудыг 2025 онд хувийн хэвшлийнхэнтэй хамтарч хийе гэж нэлээн төсөвлөж явж байгаа.

Энэ дээр ялангуяа төрийн захиргааны албан хаагчдын хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан мэдлэг, ур чадварын үнэлгээг бид энэ оны 9 сараас ер нь тусгай шалгалт зохион байгуулж хийнэ гэж төлөвлөж байсан.

Эд нар маань ер нь бусдаар гүйцэтгүүлэх гэдэг дээр орхичхоод яваад байгаа юм. Үүнээсээ тодорхой хөрөнгүүдийг хасуулж байна.

Ёс зүйн хорооны хувьд “бусдаар гүйцэтгүүлэх” гэж юуг ойлгоод байгаа юм бэ гэхээр энэ төрийн албан хаагчийн ёс зүйн төлөвшил, соёлыг хэвшүүлэх чиглүүлэх Улсын Их Хурлаас баталсан сургалт, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг бид сургагч багш нарыг бэлтгэж хэрэгжүүлэх ажлыг сая өнгөрсөн хугацаанд нэлээн хийж, багш нарыг бэлдлээ. Энэ хүмүүсээр хийлгэх ажлууд явж байна.

Ёс зүйн зөрчил, мэдээллийг ил тод болгох, цахим системийн үйл ажиллагааг бас нэвтрүүлээд эхэлж байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн индексийг тооцоолж, үүнийг хэрхэн үйл ажиллагаанд нь, үнэлгээнд нь оруулах вэ гэдгийг бас төрийн бус байгууллагаар, ялангуяа мэргэшсэн байгууллагуудаар хийлгэхээр төлөвлөөд ажиллаж байсан ийм ажлууд байгаа. Тэгээд үүнийгээ үлдсэн хөрөнгөөрөө тодорхой хэмжээний хэмнэлт гарах юм бол өөр үйл ажиллагааныхаа зардал руу оруулж үүнийгээ хийж хэрэгжүүлж дуусгая гэсэн ийм төлөвлөлттэй явж байгаа.

Тэгэхээр нөгөө “бусдаар гүйцэтгүүлэх” гэдгийг дандаа өөр хүнээр, хөндлөнгийн хүнээр хийлгэнэ гэж ойлгож болохгүй. Энэ дотор манай хоёр байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлуудаас ороод явж байгаа гэдгийг хэлье.

Ц.Сандаг-Очир: Б.Баярбаатар гишүүн 1 минут тодруулга.

Б.Баярбаатар: Одоо ингээд төсөв захиран зарцуулагч тайлбар хийхээр ингээд яг л үндсэн үйл ажиллагаа байгаа байхгүй юу. “Бусдаар гүйцэтгүүлэх” биш.

Тэгээд нэршлээсээ болоод, буруу нэршил, томъёолол доор ингэж тавьснаараа болоод тодорхой үндсэн үйл ажиллагааны хөрөнгө оруулалтаа тодотголоор тануулчхаж байгаа байхгүй юу.

Эрх биш төрийн захиргааны байгууллагын дарга, удирдлагууд чинь ингээд бас нэг хууль эрх зүйн орчноо сайн мэддэг, энэ нэр томъёогоо уг нь бас ялгадаг, салгадаг, ойлгодог л улсууд баймаар юм. Яагаад үндсэн чиг үүргийн ажлаа ингээд “бусдаар гүйцэтгүүлэх” гэж томъёолж орж ирж байдаг юм. Үүнийг л би ойлгохгүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр одоо энэ удаадаа ч өнгөрсөн. Тэгээд дараа дараа жилийнх дээр иймэрхүү зүйл орж ирвэл. Надаар тогтохгүй нэлээдгүй олон гишүүд энэ дээр эсрэг байр суурьтай санал илэрхийлэх байх шүү гэдгийг санал болгоод хэлье.

Ц.Сандаг-Очир: Үг хэллээ. Э.Болормаа гишүүн асуултаа асууя.

Э.Болормаа: Ингээд 2025 оны төсвийн тодотголтой холбоотой “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн шийдвэрийг дахиж нэг хараач ээ.

Яг ямар зарчмаар хийснийг би эхлээд тодруулъя гэж бодож байна. Асуултдаа.

Сая М.Санжаадорж дарга 182 тэрбумыг нийт “Орон нутгийн хөгжлийн сан”-гаас хассан байна гэж. Яг аль аль аймгууд дээр хэдэн төгрөгөөр, хэдэн тэрбумаар хассаныг бүр дэлгэрэнгүй гаргаж өгөөч ээ. Яг өнөөдрийн энэ мэдээлэл дунд алга.

Б.Пүрэвдорж гишүүн сая зөвхөн Ховдыг ярилаа гэхэд Увс аймаг мөн тэндээс хүмүүс бичиж байгаа нь хамгийн өндөр Увсаас хассан байна. 17 тэрбум шахуу хассан гэдэг ч юм уу.

Тэгэхээр бид оны эхэнд “Орон нутгийн хөгжлийн сан”-д нүүрсний үнэ ийм байна гээд төлөвлөөд өгдөг.

Бид Их Хурал дээр зөндөө асуусан. Өнгөрсөн намар. Энэ өөдрөг төсөөсөн үү гэсэн. Үгүй үгүй. Энэ яг зөв төсөөлсөн. Бид маш их орон зайтай төсөөлсөн гэдэг. Тэгээд орон нутгийн хүмүүс буруу байхгүй.

Одоо тэр төлөвлөлтийн алдаанаас болж бүх ажил нь гацаад байдаг.

Тэд нарт маань хүнд байгаа, ойлгож байна гээд өнгөрмөөргүй байна л даа. Одоо энэ дээр шийдэл хаймаар байгаа юм. Ирэх жилийн орлогоосоо бид нөхөх биш, энэ жил эх үүсвэрийг нь өөрчлөөд ямар боломжууд байна вэ? Энэ дээр ямар шийдэл байна вэ гэдгийг асуумаар байна.

Ц.Сандаг-Очир: Э.Болормаа гишүүний асуултад хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 3 номерын микрофон. М.Санжаадорж.

М.Санжаадорж: Сангийн яам. М.Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя.

“Орон нутгийн хөгжлийн сан”-гийн харилцаа Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйл дээр зохицуулагдаж явж байгаа.

Тэгэхээр “Орон нутгийн хөгжлийн сан”- өөрөө ямар эх үүсвэрээс бүрдэх вэ гэдгийг энэ хуулийн заалт дээр заасан байгаа юм.

Тэгэхээр яг энэ хууль дээр АМНАТ-ийн орлогын 10 хувийг гэж байгаа юм.

Нийт АМНАТ-ийг бид улсын нэгдсэн төсөвт орж ирэхээр нь эхлээд АМНАТ-аас 10 хувийг нь “Орон нутгийн хөгжлийн сан”-даа хуваарилдаг гэсэн үг.

Дараа нь энэ “Ирээдүйн өв сан”-даа бас хуваарилна гээд ингээд хуваарилагдаад хуваарилагдаад энэ эх үүсвэр маань бүгд хуваарилагддаг.

Мөн “Орон нутгийн хөгжлийн сан”- дээр нэмж хуваарилах боломжтой дүн нь хуулийн 60.2.7-гоор:

- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогыг 100 хувь.
- Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувийг

хуваарилна гэсэн хуулийн заалт байгаа.

Тэгээд үлдэх хэсэг маань бусад улсын төсөв рүүгээ ороод одоо тэр эмч, багш нарын цалин болоод явж байгаа гэсэн зүйлийг хэлэх гээд байгаа юм.

Түүнээс биш энэ дээр улсын төсвөөс хуваарилдаг дүн байхгүй. Сангийн яамнаас аль нэг аймгийг ямар нэгэн байдлаар ялгамжтай бууруулах боломж байхгүй. Энэ чинь эх үүсвэрээрээ өөрөө цаанаасаа хуваарилагдаад гараад ирж байгаа ийм зүйл учраас тэгэх боломжгүй байгаа.

Орлого буурч байгаатай холбоотойгоор “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн дүн буурч байгаа.

Аймгуудтай холбоотой буурч байгаа дүнг одоо тань руу явуулъя.

Аймгуудын хувьд яг ижилхэн жигд дунджаар 30 хувь орчмоор буурч байгаа.

Нэг ялгаатай зүйл аймгууд дээр гарч ирдэг. Тэр нь юу вэ гэхээр “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн АМНАТ-ийн тэр орлогыг бүрдүүлж байгаа, дийлэнхийг бүрдүүлж байгаа аймаг дээр арай өөр давуу талд гэх юм уу даа. Тийм томъёо бас явдаг.

Тэр нь нийт АМНАТ-ийн орлогын 60 хувийг бүрдүүлж байгаа Өмнөговь аймаг. Мөн Орхон аймаг дээр 21 хувийг бүрдүүлж байгаа. Энэ хоёр аймаг дээр арай түлхүү олгодог гэсэн үг.

Бусад 21 аймгаас уул уурхай огт явахгүй байгаа аймгууд байгаа. Үлдсэн АМНАТ-ийн тодорхой хэмжээнд төлбөр төвлөрүүлдэг үлдсэн 19 аймгийн хувьд үлдсэн хэсгийг хувааж төвлөрүүлдэг байгаа. Тийм.

Ц.Сандаг-Очир: Э.Болормаа гишүүн тодруулъя.

Э.Болормаа: Тодруулга асуулт.

Би энэ дээр ямар шийдэл байна вэ л гэж хараад байна л даа. Одоо ингээд өөрсдийн буруу төлөвлөснөөс болж аймаг, орон нутгийг ийм хэцүү

байдалд оруулчаад, ер нь хассан зарчмаа та яг тодорхой хэлчхээрэй. Бүгдээрэнгээс нь ижил 30 хувиар яг хассан юм уу? Тэгээд яг үнийн дүнг нь надад гэхээсээ илүү энэ олон нийт мэдээсэй гэдэг учир би яг аймаг, аймгаар нь таныг хэдийг хасаж байгаа юм бэ гэдгийг хэлээсэй гэж хүсэж байна.

Сүүлд нь нэмж тодруулж нэг зүйлийг хэлэхэд. Та түрүүн хэлсэн. Дорноговь, Ховд хоёр “Орон нутгийн хөгжлийн сан”-даа хандив, тусламж цуглуулдаг гэдэг ийм юм ярьсан. Энэ хандив, тусламж биш шүү.

МОНЭНКО компанитай орон нутгийн хувьд хамтран ажиллах гэрээ. Тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж, орон нутагтай хамтран ажиллах гэрээнийхээ үүргийг биелүүлж байгаа болохоос биш хандив, тусламж гэж үзэж харж болохгүй шүү. Ийм маш том. Одоо наадах чинь бүр философийн үгийн алдаа гарч байна шүү гэдгийг хэлье.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 3 номерын микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам. М.Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя.

Хандив, тусламжийн хувьд яг Төсвийн тухай хууль дээр байгаа нэршлээр нь авсан.

Аймгуудын хувьд би танд файлийг нь одоо явуулъя. Аймаг бүрээр нь уншаад өгөөч гэсэн учраас уншъя. Жишээ нь:

- Архангай аймгийн хувьд 14.5 тэрбум төгрөг батлагдсанаас тодотголоор 9.6 тэрбум төгрөг болж 4.8 тэрбумаар буурч байна. Хувьчилж хэлбэл 33.1 хувь.
- Баян-Өлгий аймгийн хувьд 14 тэрбум төгрөгөөс 9.3 болж буурч байна. Хувьчилж хэлбэл 33 хувь.
- Баянхонгор аймгийн хувьд 23.5 тэрбум төгрөгөөс 18 тэрбум төгрөг болж 5.3 тэрбум төгрөгөөр буурч байна. Хувьчилж хэлбэл 22.9 хувь.
- Булган аймгийн хувьд 15.2 тэрбум төгрөгөөс 11 тэрбум төгрөг болж байна. Нийтдээ 4.1 тэрбум төгрөг буюу хувьчилж хэлбэл 27.4 тэрбум төгрөг.
- Говь-Алтай аймаг 24.9 тэрбум байсан нь 18.3 тэрбум төгрөг болж байна. Энэ нь 26.8... /минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Гүйцээгээд хариулъя. Ажлын хэсгийн 3 номерын микрофон.

М.Санжаадорж: Дорнод аймгийн хувьд 30.4 тэрбум төгрөг байгаагаас 22.9 тэрбум төгрөг болоод нийтдээ 7.4 тэрбум төгрөг болж байна. Хувьчилж хэлбэл 24.6 хувь.

- Дундговь аймгийн хувьд 18.2 тэрбум төгрөгөөс 13.0 тэрбум төгрөг болж буурч байна. 5.2 тэрбум төгрөгөөр буюу 28.6 хувиар буурч байна.
- Завхан аймгийн хувьд 17.2 тэрбум төгрөгөөс 12.4 тэрбум буюу 28.2 хувиар.
- Өвөрхангай аймгийн хувьд 17.2 тэрбум төгрөгөөс 12.2 тэрбум төгрөг буюу 29.6 хувиар.
- Өмнөговь аймгийн хувьд 60.7 тэрбум төгрөгөөс 43.7 тэрбум төгрөг болж буурч байна. Энэ нь 27.9 хувиар буурч байна.
- Сүхбаатар аймгийн хувьд 26.5 тэрбум төгрөгөөс 19.7 тэрбум төгрөг буюу 25.8 хувиар буурч байна.
- Сэлэнгэ аймгийн хувьд 31.3 тэрбум төгрөгөөс 23 тэрбум төгрөг болж буурч байна. Энэ нь 26.3 хувиар буурч байна.
- Төв аймгийн хувьд 28... /минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Дунджаар ер нь 24-өөс 33 хувиар буурч байгаа юм байна. Тийм үү?

Нэмэлт тодруулга авсан. 2 удаа авчихлаа. Шаардлагатай бол Э.Болормаа гишүүнд бүх аймгуудын “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн төсвийг өгчих. Тийм.

Ц.Сандаг-Очир: О.Алтангэрэл гишүүн асуултаа асууя.

О.Алтангэрэл: Энэ архидалтын асуудал Монголын их том асуудал болоод байгаа юм.

Тэгээд энэ архины эмчилгээний асуудал, албадан эмчилгээний асуудал их ноцтой асуудал байгаа.

Дорнод аймагт нэг архины албадан эмчилгээ бий. Өвөрхангай аймагт сарын өмнө бага хэмжээний албадан эмчлэх төв байгуулагдсан. Баянхонгор аймагт энэ намар орох гэж байгаа юм.

Тэгээд энэ бүх үйл ажиллагаанууд яг л энэ архинаас хамааралтай хүмүүс, тэр хүмүүсийн эргэн тойронд зовж байгаа хүмүүсийн зовлон шаналалыг багасах, дондолтыг нь эмчлэх зорилгоор яваад.

Төрөөс яг энэ рүү мөнгө чиглүүлээд тавиад ингээд явж байх бололцоог ойлгож байна. Төсөв хүндэрсэн. Тодотгол хийж байгааг ойлгож байна.

Тэгэхдээ “Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сан” гээд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар нэг ийм сан байгаа.

Яг өнөөгийн байдлаар үлдэгдэл нь 19.2 тэрбум төгрөг байна. Энэ ерөөсөө төртэй хамааралгүй мөнгө шүү дээ.

Энэ архи согтууруулах ундаа үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжүүд маань литр тутмаас нь хэд билээ, 80 төгрөг билүү өгөөд ингэж хуримтлагдсаар байгаад төрөөс ямар ч хамааралгүй тэр санд хуримтлагдсан мөнгө байгаа юм.

Тэгээд энэ мөнгийг уг нь энэ жил Мааньтын олон жил болж байгаа согтуурах, мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх албадан хөдөлмөрлүүлдэг төв барилга, байшин асар их муудсан, эм тариагүй. Нэн ялангуяа Монгол Улсад өнөөдөр мансууруулах бодисын хамааралтай хүнийг албадаж эмчилдэг ямар ч төв, дэд бүтэц алга байна. Энд зориулъя гэсэн чинь төсөв хэлэлцэх үеэр энэ чинь төртэй ямар ч хамаагүй мөнгө байна шүү дээ гэсээр байхад л 1 тэрбум төгрөгөөр зарцуулалтыг нь хязгаарласан.

Уг нь энэ мөнгийг энэ Мааньтын албадан эмчилгээн дээр нэг шинэ төв бариад яг энэ согтуурах болон мансууруулах донтой өвчтөнийг албадан эмчлэхэд зарцуулмаар байгаа юм.

Тэгээд энэ хязгаарлалт маань энэ тодотгол дээр яг хэвээрээ байгаа юу? Энэ тэртээ тэргүй төрийн мөнгө биш. Аж ахуй нэгжүүдээс санд хуримтлагддаг мөнгийг зориулалтын дагуу зарцуулах ямар нэг боломж бололцоо байна уу? Энэ дээр ямар төлөвлөгөө байна вэ гэсэн ийм асуулт.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 3 номерын микрофон. О.Алтангэрэл гишүүний асуултад хариулъя.

М.Санжаадорж: Сангийн яам. М.Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя.

Архидан согтуурахтай тэмцэх сангийн хувьд улсын төсвийн санхүүжилтээс гэхээсээ илүү өөрийн орлогоор гэх юм уу, ногдуулсан орлоготой байгаа учраас. Тодорхой хэлэх юм бол согтууруулах ундааны литр тутамд тодорхой тарифаар хөрөнгө хуримтлагдаж байгаа. Хөрөнгийн хэмжээ сар

болгон дунджаар 700 орчим сая төгрөг орж ирж байгаа. Бид санд хуваарилаад явж байгаа.

Нөгөө тал даа та үүнийг яаж зарцуулах вэ гэдэг асуулт асууж байна. Бид зарцуулалтыг нэмье гэхээр энэ нэг талдаа өөрөө эх үүсвэртэй, орлоготой юм шиг боловч нөгөө талдаа нийт зарлагын хэмжээнд орж яваад байгаа юм.

Тэгэхээр бид энэ сангийн зарлагыг нэмэгдүүлэх юм бол нэгдсэн төсвийн нийт зарлага бас өөрөө нэмэгдэх болоод. Тэгээд зарлага нэмэгдүүлэх дээр очиж гараад.

Одоогийн энэ тодотголоор бид зөвхөн 3 янзын зардлыг нэмж оруулж ирсэн байгаа. Үүнд энэ архидан согтуурахтай тэмцэх сангийн зардал орж ирээгүй.

Ирэх жилийн төсвийг одоо бид 07 сарын 25-наас хэлэлцэж эхлээд тэгээд 09 сарын 01-нд Улсын Их Хуралд цаглаврынх нь дагуу өргөн мэдүүлэхээр байгаа.

Энэ үедээ энэ сангийн зарцуулах зарцуулалтыг өөрийн өмнөх жилүүдэд хуримтлагдсан орлогынхоо хүрээнд бас нэмэгдүүлэх талаар зохих арга хэмжээг төсвийн тухайн үеийнхээ ерөнхийлөн захирагч яамтай нь тухайн үед нь ярьж байгаад бас оруулж ирээд аая гэсэн ийм төлөвлөгөөтэй байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Би нэг асуулт асууя.

Онцгой байдлын ерөнхий газрын дарга генерал байж байна.

М.Санжаадорж оо, энэ жил улс орон даяар их хуурайшилттай, зуншлага муутай ийм байна. Аймгууд, олон газруудад түймэртэй байна. Энэ үед төсвийн тодотгол нэрээр Онцгой байдлын ерөнхий газар, онцгой байдлын албаныхны үйл ажиллагааны зардал дээр Та бүхэн яаж хандаж байгаа вэ? Төсөв санхүү, зардлыг нь хасаж байна уу? Нэмэгдүүлж байгаа юм байна уу? Энэ алба хаагчид үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл байдлаар хангагдсан уу?

Монгол Улсын газар нутаг, ой, байгалийн баялаг шатаж байхад төсвөөр дутаж болохгүй байх аа. Энэ дээр яаж мэдрэмжтэй хандаж байгаа вэ? Бүгдийг нь тэгшитгээд хасаж байгаа юу, үгүй юу?

Эхлээд Онцгой байдлын ерөнхий газрын Г.Ариунбуян дарга түймэртэй талаар мэдээлэл өгөөч. Хэчнээн газар нутаг дээр түймрийн нөхцөл байдал байна? Хэчнээн албан хаагчид ажиллаж байна? Нөхцөл байдал ямар байна? Энэ тал дээр төсөв, санхүү нь ямар байгаа гэдэг тал дээр М.Санжаадорж дараа нь хариулна.

Ажлын хэсгийн 4 дэх микрофоныг өгье. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, генерал Г.Ариунбуян дарга хариулна.

Г.Ариунбуян: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая.

Байнгын хорооны даргын асуултад хариулъя.

Өнөөдөр улсын хэмжээнд 1 түймэртэй байгаа. 2025 он гарсаар нийт 144 удаагийн ой хээрийн түймэр бүртгэгдсэн. Энэ түймрийн одоо дийлэнх нь буюу 30 гаруй хувь нь Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт бүртгэгдсэн байгаа юм.

Тэгээд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал ойн түймрийн хувьд 75 хувиар, хээрийн түймрийн хувьд 17 орчим хувиар өссөн үзүүлэлттэй байгаа. Нийт дүнгээрээ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 50 хувиар өссөн үзүүлэлт байна.

Одоо энэ ой хээрийн гал түймэрт урьдчилсан байдлаар 68 мянга 300 орчим га ойн талбай, хээрийн 570 орчим мянган га талбай өртсөн.

Урьдчилсан байдлаар 6 орчим тэрбум төгрөгийн хохирол учирсан гэсэн ийм мэдээлэл байгаа.

Түймэр унтраах ажиллагаанд онцгой байдлын байгууллагаас давхардсан тоогоор 2900 гаруй албан хаагч, мөн хилийн цэрэг, цагдаа, зэвсэгт хүчин, орон нутгийн мэргэжлийн анги буюу иргэд гээд 4500 гаруй хүн. Нийт 7700 гаруй хүн, 1200 гаруй автомашин, 3 нисдэг тэрэгтэйгээр үйл ажиллагаа явууллаа.

Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд 1 түймрийг унтраахаар ажиллаж байна. 3 түймэр буюу Мандал сум, Хүдэр сум, Алтанбулагийн түймэр цурманд орсон. Тухайн түймрийг унтраахаар онцгой байдлын байгууллагаас 430 албан хаагч, 30 автомашин, орон нутгийн ард иргэд 110 хүнтэй ажиллаж байна.

Онцгой байдлын байгууллагын төсөв, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх талаар Улсын Их Хурал, Засгийн газраас онцгойлон анхаарсаар ирсэн. Тэгэхдээ бидний хувьд үнэхээр хэрэгцээ шаардлага бий. Орон нутагт хуурайшилт ихтэй хүн, хүчээ төвлөрүүлж ажиллахад зайлшгүй нийслэл, бусад говийн аймаг, зүүн бүсийн аймгуудын хүч хэрэгслэлийг бүгдийг нь татаж оролцуулж байгаа.

Тэгэхээр цаашдаа үе шаттайгаар хүн хүчний тоог нэмэгдүүлэх, техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүл асуудал чухал.

Сангийн яамтай бид ярьсан. Тэгээд төр, засгийн бодлого хэрэгжиж байгаа. Бүсээ чангалах, төрийн хэмнэлтийн горим мөрдөгдөж байгаа учраас 9 хувиар орон тоогоо зохицуулах, бууруулах. Тэгэхдээ эндээ аль болохоор гал унтраах анги салбарын хүрээнд биш дунд түвшний мэргэжилтнүүдийн хүрээнд

дотооддоо зохицуулалт хийх замаар өөрчлөхөөр урьдчилсан байдлаар ярьсан байгаа.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 3 номерын микрофон. М.Санжаадорж.

М.Санжаадорж: Сангийн яам. М.Санжаадорж. Байнгын хорооны даргын асуултад хариулъя.

Онцгой байдлын байгууллагаас 2025 оны төсвийн тодотголоор 26.8 тэрбум төгрөг буурсан байна. Үүнээс дийлэнх нь төрийн албан хаагчдын орон тоог 9 хувь бууруулахтай холбоотой зардал орж ирсэн байна.

Онцгой байдлын байгууллагын ер нь энэ хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цаашдын авч хэрэгжүүлэх стратеги, энэ бүх асуудлуудыг Сангийн яамны хувьд маш сайн ойлгож байгаа.

Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан сайдаас бидэнд бас энэ тал дээр хамтран ажиллах албан бичиг ирсэн байгаа. Онцгой байдлын байгууллагад Сангийн яамны хувьд ажиллаад эхэлсэн байгаа. Ирэх жилийн төсөв дээр.

Тэгэхээр хэрэгцээ шаардлагыг эхний ээлжид бид судалж үзэхэд орон тоо дахиад 8 мянга орчмоор нэмэгдэх шаардлагатай.

Мөн стратегээ өөрчилсөн. Энэ дагуу бид техник, тоног төхөөрөмжийг сайжруулах шаардлагатай гэсэн байдлаар эхний тооцоог... /минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.5 дахь хэсэгт бусад Байнгын хороо Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд гишүүн, нам, эвслийн бүлэг, төрийн аудитын төв байгууллага саналаа зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт гаргана гэж заасны хүрээнд санал гаргах гишүүд байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж явуулж дууслаа.

Дараагийн асуудалд оръё.

Зургаа. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

/Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 3 гишүүн 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 11 гишүүн 2025.06.10-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

/Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 26 гишүүн 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

/Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн/

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл

/Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 9 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

/Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нарын 20 гишүүн 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн/
Анхны хэлэлцүүлэг

Тав дахь асуудал. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 3 гишүүн 2025 оны 03 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлгийг явуулна.

Хуулийн төслүүдийг нэгтгэн Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар танилцуулна.

Б.Баярбаатар гишүүний микрофоныг өгье.

Б.Баярбаатар: Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 3 гишүүн 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 11 гишүүн 2025 оны 06 сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 26 гишүүн 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Улсын Их Хурал Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 10 гишүүн 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 9 гишүүн 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн хуулийн төсөл.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслүүд. Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нарын 20 гишүүнээс 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэн Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг Та бүхэнд танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 3 гишүүн санаачлан боловсруулж 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 11 гишүүн санаачлан боловсруулж 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 26 гишүүн санаачлан боловсруулж 2025 оны 03 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 10 гишүүн санаачлан боловсруулж 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 9 гишүүн санаачлан боловсруулж 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нарын 20 гишүүн санаачлан боловсруулж 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг 2025 оны 06 сарын 23, 25-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.26-д нэг асуудлаар ба хоёр ба түүнээс дээш хуулийн төсөл өргөн мэдүүлсэн бөгөөд хууль санаачлагчид нэгтгэн хэлэлцэхийг зөвшөөрсөн бол Байнгын хороо тэдгээрийн анхны хэлэлцүүлгийн шатад нэгтгэн нэг төсөл болгож, Байнгын хорооны санал, дүгнэлтийг хамтаар нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлнэ гэж заасныг үндэслэн дээр дурдсан гишүүдээс санаачлан өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэн Байнгын хороо болон нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 288 дугаар захирамжаар Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Н.Алтаншагай, П.Сайнзориг, Г.Уянгахишиг, Ө.Шижир нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Ажлын хэсэг 2025 оны 06 дугаар сарын 29, 07 дугаар сарын 01-ний өдрүүдэд хуралдсан бөгөөд хуралдаанд хуралдаанд хууль санаачлагч Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, О.Цогтгэрэл, Б.Бат-Эрдэнэ, А.Ариунзаяа, Х.Булгантуяа нарын хуулийн төслийн талаар танилцуулгыг сонсож, ажлын хэсгийн гишүүд хууль санаачлагчдаас асуулт асууж, хариулт авсан болно.

Хууль санаачлагч Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, О.Цогтгэрэл, Б.Бат-Эрдэнэ, А.Ариунзаяа, Х.Булгантуяа нараас Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийг нэгтгэн хэлэлцэхийг дэмжиж байгаа бөгөөд ажлын хэсгийн хуралдаанаар хуулийн төслүүдийг нэгтгэн Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэхийг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүд 100 хувийн саналаар дэмжсэн болно.

Ажлын хэсэг нэгтгэсэн төсөлд Агаар, орчны бохирдлын дэд хорооны эрхлэх асуудлыг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын гишүүдийн өргөн мэдүүлсэн төсөл болон Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын гишүүдийн өргөн мэдүүлсэн төсөлд агуулга нь адилхан ч томъёолол зөрүүтэйгээр өргөн мэдүүлснийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын гишүүдийн төслөөр нэгтгэсэн болно.

Мөн хууль санаачлагчид хуулийн төслийг дагаж мөрдөх хугацааг ялгаатайгаар өргөн мэдүүлсэн бөгөөд Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын гишүүдийн өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Х.Тэмүүжин нарын гишүүдийн өргөн мэдүүлсэн хуулийн хоёр төсөл, О.Цогтгэрэл нарын гишүүдийн өргөн мэдүүлсэн хуулийн төсөл нь батлагдсан өдрөөс дагаж мөрдөхөөр тусгасан тул нэгдсэн төсөл батлагдсан өдрөөс гэж дагаж мөрдөхөөр тусгалаа.

Ажлын хэсгийн хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийг нэгтгэн хэлэлцэж 17 зарчмын зөрүүтэй саналын томъёолол боловсруулан Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр танилцуулж байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Дээрх хуулийн төслийн талаарх ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа. Ажлын хэсэг.

Ц.Сандаг-Очир: Б.Баярбаатар гишүүнд баярлалаа.

Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 6 хууль байгаа. Хууль санаачлагч нар хуулийн төслүүдийг нэгтгэхийг дэмжсэн, гарын үсгээ зурсан байгаа.

Хуулийн төслүүдийг нэгтгэсэнд тооцлоо. /алх цохив/

Санал хураалтууддаа орно.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа гишүүн танилцуулна.

Х.Болормаа гишүүний микрофоныг өгье.

Х.Болормаа: Сайн байцгаана уу? Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа нарын 20 гишүүн 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 06 сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2025 оны 06 сарын 27-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу явуулж хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд тусгагдсан Улсын Их Хурлаар төсөв хэлэлцэхтэй холбоотой 69 дүгээр зүйлийг хасах санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллийг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүгдээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Х.Болормаа гишүүнд баярлалаа.

Одоо Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, дэгийн байнгын хорооны гишүүн Г.Очирбат танилцуулна. 3 санал, дүгнэлт байгаа.

Г.Очирбат гишүүний микрофоныг өгье.

Г.Очирбат: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарын 11 гишүүн 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлсэн.

Ёс зүй, дэгийн байнгын хороо өөрийн эрхлэх асуудлын хүрээнд 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт заасны дагуу дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт болон зарчмын зөрүүтэй санал ирээгүй болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: 3 санал байгаа. Тийм.

Г.Очирбат: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа нарын 9 гишүүн 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэх эсэх асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлсэн.

Ёс зүй, дэгийн байнгын хороо өөрийн эрхлэх асуудлын хүрээнд 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл төслийн 1 дүгээр зүйлийн “Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухаан” гэснээс “шинжлэх ухааны” гэснийг хасаж, Эдийн засгийн байнгын хороонд Шинжлэх ухаан, технологи, инновацын дэд хороог байгуулах саналыг дэмжих, мөн Монгол Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Хэрлэн уг саналыг дэмжиж байгаагаа илэрхийлж үг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Ц.Сандаг-Очир: Одоо гурав дахь санал, дүгнэлт ээ.

Г.Очирбат: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа нарын 20 гишүүний 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлсэн.

Ёс зүй, дэгийн байнгын хороо өөрийн эрхлэх асуудлын хүрээнд 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт заасны дагуу дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхлан төсвийн тогтолцооны хувьд их том өөрчлөлт буюу сүүлийн 34 жилийн төсвийн цаг хугацааны цаглавар өөрчлөгдөж байгаа. Үүнээс улбаалан Засгийн газрын төсвийг төлөвлөхөд эрсдэл үүсэх, мөн төсвийн хэлэлцүүлгийн үе шат 4 байсныг 5 болгож байгаа зэрэг өөрчлөлтүүдийг хуучнаар нь байлгах боломжтой эсэх, Засгийн газраас албан ёсоор санал аваагүй, төсвийн төслийн хэлэлцүүлгийг хийх бүрэлдэхүүний талаар болон улмаар Улсын Их Хурал төсвөө баталж чадахгүйд хүрэх эрсдэлтэй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар тухайн жилийн төсөв 09 дүгээр сарын 01-нд өргөн барих хэвээрээ байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Дүгэрийн Рэгдэл төслийн 71.2 дахь хэсэгт “Байнгын хороо болон дэд хороо” гэснийг аль дэд хороо гэдгийг тодорхой тусгах шаардлагатай эсэх талаар асуулт асууж, үг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсан Та бүхэн баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Г.Очирбат гишүүнд баярлалаа.

Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10 Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Хэрэв төслийн зүйлээр хуульд шинээр бүлэг, дэд бүлэг, нэмэх, бүлэг, дэд бүлгийнх бүхэлд нь өөрчлөх бол тухайн бүлгийн зүйл дээр хэлэлцэнэ гэсэн байгаа.

Ингээд хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. /алх цохив/

Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгана. Танилцуулна.

1.Ажлын хэсгээс нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.26 дахь хэсгийн “Хүний эрхийн Үндэсний Комисс” гэсний дараа “Үндэсний статистикийн хороо” гэж, мөн заалтын 21.25, 21.30 дахь хэсгийн “мэдээллийг” гэсний дараа “санаатайгаар” гэж, мөн зүйлийн 5 дахь заалт буюу 23.8.1 дэх заалтын “судлах” гэсний дараа “холбогдох Байнгын хорооны саналыг үндэслэн тухайн асуудлаар холбогдох байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл авах, сонсох” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Н.Алтаншагай, П.Сайнзориг, Г.Уянгахишиг, Ө.Шижир. Цаашид “Ажлын хэсэг” гэх.

Санал хураалтдаа бэлдье. Гишүүд ээ.

Саяын уншсан ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. /алх цохив/

20 Гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 65.0 хувиар санал дэмжигдлээ.

2.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 21.26 дахь хэсгийн “21.25-д” гэснийг “21.24-д” гэж, мөн заалтын 21.28 дахь хэсгийн “Улсын Их Хуралд” гэснийг, мөн 21.30 дахь хэсгийн “нэгдсэн хуралдаанд” гэснийг “Улсын Их Хурлын асуулгын цаг, Тусгай хяналтын дэд хорооны сонсгол, Хяналт шалгалтын түр хорооны сонсгол болон хяналтын сонсголд, эсвэл нэгдсэн хуралдаанаар гишүүний асуулгын хариу, улсын төсөв, төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэхэд” гэж тус тус, мөн 21.28 дахь хэсгийн “тухайн нам, эвслийн бүлэг, эсвэл 10-аас” гэснийг “нам, эвслийн бүлэг, эсвэл 20-оос” гэж, 21.30 дахь хэсгийн “32.7-д” гэснийг “32.8-д” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 14 гэж гишүүн дэмжиж, 70 хувиар санал дэмжигдлээ.

1 дүгээр зүйлээр санал хурааж дууслаа. /алх цохив/

Одоо Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй ажлын хэсгээс ирсэн санал байхгүй байна. Тийм үү?

Байхгүй байна. /алх цохив/

2 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Улсын Их Хурлын тухай хуулийн 3 дугаар зүйл дээр асуух асуулттай гишүүн, саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. /алх цохив/

Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал ирсэн.

Саналын томъёололыг уншиж танилцуулъя.

1.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 21.24 дэх хэсгийн “Тусгай хяналтын дэд хороо” гэсний дараа “Хяналтын сонсгол болон” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 14 гишүүн дэмжиж, 70 хувиар санал дэмжигдлээ.

2.Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 22.6.7 дахь заалтын, мөн зүйлийн 4 дэх заалт буюу 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсгийн,

мөн зүйлийн 6 дахь заалт буюу 27.3.3 дахь заалтын “Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны” гэснийг “Хүний хөгжил, нийгмийн бодлогын” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 14 гишүүн дэмжиж, 70.0 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн 3 дугаар зүйл дээр гишүүдээс ирсэн зарчмын зөрүүтэй саналуудыг танилцуулж санал хураалгая.

С.Зулпхар гишүүн, Л.Энхнасан гишүүн, М.Бадамсүрэн гишүүн, Ц.Мөнхтуяа нарын гишүүдээс ирсэн саналыг. Зөрүүтэй томъёололыг. Дөрвүүлээ ижилхэн юм уу? Аан за.

С.Зулпхар гишүүн өөрөө танилцуулах уу? Таны зарчмын зөрүүтэй саналыг хураалгах гэж байна. Би эндээс бичгээр ирснээр нь танилцуулах юм уу?

Та өөрөө танилцуулчих. Санал гаргасан С.Зулпхар гишүүн өөрөө саналаа танилцуулъя.

С.Зулпхар гишүүний микрофоныг өгье.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүдийн дахин амар амгаланг айлтгая.

Зэрэг зэрэг Байнгын хороо руу гүйгээд өнөөдөр их тийм завгүй мөртлөө ажил хэрэг их өндөртэй өдөр болж байх шиг байна.

Энэ хуульд шинэ зохицуулалт хийгдсэн.

Тэр нь зарим Байнгын хороодыг татан буулгаж байгаа асуудал байгаа. Тэгээд үүнтэй холбогдуулаад бид Боловсролын боловсрол, шинжлэх ухаан, спортын байнгын хороог хэвээр нь үлдээх ёстой гэсэн үндэслэл гаргаж байгаа юм. Үндэслэлээ дараах байдлаар тайлбарлаж байгаа юм л даа.

“Алсын хараа-2050”-ийг боловсруулж байх үед бид нэг зүйлийг их чухалчилж хийсэн юм. Цаашдаа ер нь Засгийн газрын бүтэц бай, Их Хурлын бүтэц ч бай зорилго руугаа чиглэсэн, зорилготойгоо нийцсэн бүтцүүд байна. Тэр нь ямар байх нь тухайн үедээ шийдэгдэнэ гээд.

Тэгээд 2020 оны Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээр энэ Байнгын хороо шинээр байгуулагдсан. Байгуулагдах нь яах вэ, тухайн үеийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, 2024 оны сонгуулийн үр дүнгээр

байгуулагдсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт боловсролын салбарыг бид тэргүүлэх чиглэл болгоод тодорхойлсон. Зорилт болгоод.

Тэгээд ийм зорилтууд байж байгаа. Нөгөөтээгүүр 2026 оныг Монгол Улсын Засгийн газар “Боловсролыг дэмжих жил” болгоод зарласан.

Бид боловсролтой холбоотой асуудлыг бодлогын түвшинд нь, хууль нь ч байсан. Бусад тогтоол нь ч байсан. Тухайлан хэлэлцдэг мэргэшсэн зохион байгуулалтын хэлбэр Улсын Их Хуралд байх ёстой гэж үзсэний үндсэн дээрээс энэ Байнгын хороо байгуулагдсан юм.

Тэгээд энэ хуулиар үүнийг татан буулгаж байгаа юм байна.

Тийм учраас бидний хэсэг нөхдийн. Би их олон хүнийг бас төлөөлж байгаа гэдгийг хэлье. Зорилго бол үүнийг татан буулгахгүйгээр хуульд нь зарчмын зөрүүтэй санал хураалгаад хэвээр нь үлдээх хүсэлтэй байгаа. Үүнтэй холбоотой томъёоллыг энд их нарийвчилж хийсэн байгаа. Энэ бол 1 дүгээр зүйлийн 3 дробь таслал 7 дробь таслал, 8 дробь таслал, 4 дүгээр зүйл, 6 дугаар зүйл байгаа юм. Үүнтэй холбоотой санал байгаа юм.

Саналын томъёоллийг би Та бүхэнд уншиж танилцуулъя.

Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтыг “22.6.7.Нийгмийн бодлогын” гэж өөрчлөх, мөн зүйлийн 4 дэх заалтаас 23.7.1, 23.7.3, 23.7.4, 23.7.6, 23.7.7, 23.7.8, 23.7.11 заалтыг, мөн зүйлийн 6 дахь заалтаас 27.3.3 дахь заалтыг, мөн зүйлийн 7 дахь заалтаас 27.5.6 дахь заалтыг, 6 дугаар зүйлээс 22.6.4, 23.4 гэснийг тус тус хасах.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлээс 115 дугаар зүйлийн 115.2.8, 115.2.12, 115.2.16 дахь заалтын “Нийгмийн бодлогын” гэснийг “Нийгмийн бодлого, боловсрол, шинжлэх ухааны” гэснийг хасах гээд.

Тэгээд ийм байдлаар бид зарчмын зөрүүтэй санал хураалгахаар оруулж ирж байна. Томъёоллыг Тамгын газрынхантай зөвлөлдсөн. Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаныхантай бас зөвлөлдсөн. Ингээд оруулж ирж байгаа томъёолол байгаа юм.

Ингээд саяын томъёоллоор нь санал хураалгах юм бол хуульд саяын Байнгын хороо маань хэвээр үлдэх ийм байгаа шүү гэдгийг хэлье. Та бүхнийг дэмжиж саналаа өгөхийг хүсье. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: С.Зулпхар гишүүнд баярлалаа. С.Зулпхар гишүүний танилцуулсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Үндсэндээ Нийгмийн бодлогын байнгын хороонд Боловсролын байнгын хороог нэгтгэж байгаа. Үүнийг хасахгүй. Одоогийн байгаагаар нь хэвээр үлдээе гэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол байгаа юм.

С.Зулпхар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 6 гишүүн дэмжиж, 30 хувиар санал дэмжигдсэнгүй.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан гишүүний зарчмын зөрүүтэй саналын томьёололыг уншиж танилцуулъя.

Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтыг “22.6.7.Нийгмийн бодлогын” гэж өөрчлөх, мөн зүйлийн 4 дэх заалтаас 23.7.1, 23.7.3, 23.7.4, 23.7.6, 23.7.7, 23.7.8, 23.7.11 дэх заалтыг, мөн зүйлийн 6 дахь заалтаас 27.3.3 дахь заалтыг, мөн зүйлийн 7 дахь заалтаас 27.5.6 дахь заалтыг, төслийн 6 дугаар зүйлийн 22.6.4-22.6.6 гэснийг 22.6.5, 22.6.6 гэж өөрчилж, 23.4 гэснийг хасах. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлээс 115 дугаар зүйлийн 115.2.8, 115.2.12, 115.2.16 дахь заалтын “Нийгмийн бодлогын” гэснийг “Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны” гэснийг хасах.

Мөн адилхан яг С.Зулпхар гишүүнтэй адилхан санал юм байна.

Санал хураалт. Л.Энхнасан гишүүний зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 4 гишүүн дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

Мөн М.Бадамсүрэн гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Яг мөн адилхан юм байна.

Тэгэхээр унших шаардлага байна уу? Саналын томьёололыг. Тэгвэл М.Бадамсүрэн гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёололыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

20 гишүүнээс 5 гишүүн дэмжиж, 25 хувиар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа гишүүнээс яг мөн адилхан зарчмын зөрүүтэй саналын томьёолол ирүүлсэн байна. Ц.Мөнхтуяа гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

20 гишүүнээс 6 гишүүн дэмжиж, 30 хувиар Ц.Мөнхтуяа гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнгүй.

Мөн М.Бадамсүрэн гишүүний зарчмын зөрүүтэй саналын томьёололыг уншиж танилцуулъя.

Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 6, 7 дахь заалтуудыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Төслийн 6 дахь заалтын 27.3.7 дахь заалтаас “Жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн” гэснийг 7 дахь заалтын 27.5.4 дэх заалтыг тус тус хасах. Мөн 3 дугаар зүйлийн 22.6 дахь хэсэгт “Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо” гэж нэмэх, 6 дугаар зүйлээс 22.6.1, 23.1 гэснийг хасах.

Үндсэндээ Аж үйлдвэржилтийн байнгын хороог хэвээр үлдээе л гэсэн утгатай юм байна. Санал нь.

М.Бадамсүрэн гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 4 гишүүн дэмжиж, 20 хувиар санал дэмжигдсэнгүй.

Төслийн 3 дугаар зүйл дээр ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томьёололыг уншиж танилцуулъя.

Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 27 дугаар зүйлийн 27.3.3 дахь заалтын, мөн зүйлийн 7 дахь заалт буюу 27.5.14 дэх заалтын “шинжлэх ухааны” гэснийг “боловсрол, шинжлэх ухааны” гэж, 27.5.1 дэх заалтын “асуудлаарх” гэснийг “талаарх” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Яг үүнтэй агуулгатай нэгтэй Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин гишүүн санал гаргасан байна.

27.3.3 дахь хэсгийн Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд “Соёл, спорт, залуучуудын шинжлэх ухааны” гэснийг “Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд Соёл спорт, залуучуудын боловсрол, шинжлэх ухааны” гэж өөрчлөх.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл гишүүнээс Эдийн засгийн байнгын хороонд “жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн, шинжлэх ухаан, технологи, инновацын хөгжлийн, цахим бодлогын хөгжлийн, тогтвортой хөгжлийн зорилгын” гэж өөрчлөх гэсэн зарчмын зөрүүтэй саналуудыг ирүүлсэн байна.

Мөн Д.Рэгдэл гишүүнээс 23.11.29-ийг “шинжлэх ухаан, технологи, инновац, нэгдсэн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн хяналт, үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх,

хувийн хэвшлийн оролцоог дэмжих бодлого” гэж өөрчлөх, 23.11.30-ийг шинжлэх ухаан, технологи, инновацын дэд бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг хөгжүүлэх бодлого” гэж өөрчлөх, 2.23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсгээс “шинжлэх ухааны” гэснийг хасах, 23.7.11-ийг хасах, 23.3.3-аас “шинжлэх ухааны” гэснийг хасах, 27.5.5-ыг “Цахим бодлогын хөгжлийн дэд хороо, “Цахим хөгжлийн бодлогын асуудлыг” гэж өөрчлөх, “27.5.6.Шинжлэх ухаан, технологи, инновацын дэд хороо шинжлэх ухааны салбарын нэгдсэн бодлогын асуудлыг” гэсэн шинэ заалт оруулах. Үүнтэй холбогдуулан 27.5.6-27.5.13 хүртэлх заалтуудын дэс дугаарыг өөрчлөх гэсэн зарчмын зөрүүтэй саналуудыг ирүүлсэн байна.

Эхлээд ажлын хэсгийн гаргасан түрүүний уншсан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 14 гишүүн дэмжиж, 70 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн ажлын хэсгийн саналыг танилцуулъя.

Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалт буюу 27 дугаар зүйлийн 27.3.7 дахь заалтын “Эдийн засгийн байнгын хороонд” гэсний дараа “аялал жуулчлалын хөгжлийн” гэж нэмж, мөн зүйлийн 7 дахь заалтад доор дурдсан агуулгатай 27.5.2 дахь заалт нэмэх:

“27.5.2.Аялал жуулчлалын хөгжлийн дэд хороо нь аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын асуудлыг;”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 15 гишүүн дэмжиж, 75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр гишүүнээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллын уншиж танилцуулъя.

1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалтын 27.3.6 дахь заалтын “Хууль сахиулах ажиллагааны тухай хяналтын” гэснийг хасах гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 1 гишүүн дэмжиж, 5 хувиар санал дэмжигдсэнгүй.

Б.Энхбаяр гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй 2 дахь саналын томьёоллын уншиж танилцуулъя.

2.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 27.5.9 дэх заалтын “тагнуулын гүйцэтгэх” гэснийг “тагнуулын болон гүйцэтгэх” гэж өөрчлөх.

Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 1 гишүүн дэмжиж, 5 хувиар санал дэмжигдсэнгүй.

Гурав дахь зарчмын зөрүүтэй саналын томьёололыг уншиж танилцуулъя.

3.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 27.5.11 дэх заалтыг хасах гэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёололыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 1 гишүүн дэмжиж, 5 хувиар Б.Энхбаяр гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнгүй.

Одоо 7 дахь ажлын хэсгийн саналаар санал хураалт явуулна.

Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалтын 27.5.9 дэх заалтын “тагнуулын гүйцэтгэх” гэснийг “тагнуулын болон цэргийн тагнуулын байгууллагын гүйцэтгэх” гэж өөрчилж, мөн зүйлийн 27.5.11 дэх заалтын “явуулж байгаа” гэсний дараа “тагнуулын болон цэргийн тагнуулын байгууллагад харьяалуулснаас бусад” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 15 гишүүн дэмжиж, 75.0 хувиар санал дэмжигдлээ.

Одоо Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? 4 дүгээр зүйл дээр.

Байхгүй байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал байна уу?

Ирээгүй байна. /алх цохив/

Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 5 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал байна уу?

Байхгүй байна. /алх цохив/

Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 6 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал байгаа юу?

Байхгүй байна. /алх цохив/

Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 7 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал ирсэн үү?

Байхгүй байна. /алх цохив/

Нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 15 гишүүн дэмжиж, 75.0 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу?

Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал байгаа юм байна. Ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёололыг уншиж танилцуулъя.

1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 69¹ дүгээр зүйлийн 69³ дахь хэсгийн “төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт төсвийн төслийн талаарх илтгэлийг Ерөнхий сайд танилцуулна.” гэснийг хасаж, мөн хэсгийн “илтгэлд” гэснийг “танилцуулгад” гэж, мөн зүйлийн “69^{1.5} дахь хэсгийн 69^{1.3} дахь” гэснийг “69^{1.4}-д” гэж, мөн зүйлийн 3 дахь заалт буюу 73^{1.1} дэх хэсгийн “хууль болон хамт баталсан хууль, тогтоолд” гэснийг “хуульд” гэж,

“хууль, тогтоол” гэснийг “хуулийг” гэж, “хоригийн шинж байдлыг харгалзан” гэснийг “Төсвийн байнгын хорооны саналаар” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 65.0 хувиар санал дэмжигдлээ.

Мөн зарчмын зөрүүтэй санал ирсэн байна.

Төслийн 1 дүгээр зүйл дээр Төсвийн байнгын хорооноос ирсэн.

Ж.Батжаргал гишүүний гаргасан саналын томьёоллын уншиж танилцуулъя.

Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал юм байна шүү. Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналын томьёоллын уншиж танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлд тусгагдсан Улсын Их Хурлаар төсөв хэлэлцэхтэй холбоотой 69¹ дүгээр зүйлийг хасъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 60.0 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулттай гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал байгаа юу?

Байхгүй байна. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулттай гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал байгаа юу? 3 дээр байгаа юм байна.

Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналын томьёоллын уншиж танилцуулъя.

Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 64.1.1 дэх заалтын “үг хэлэх” гэснийг “үг хэлж болно.”, төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хоёр

дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороод, Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлнэ.” гэж, 64.1.3 дахь заалтыг “үг хэлэх” гэснийг “үг хэлж болно.”, нэгдсэн хуралдаан энэ хуулийн 64.1.2-т заасан санал тус бүрээр ил санал хураалт явуулна гэж өөрчилж, 64.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“64.1.2.хоёр дахь хэлэлцүүлгээр Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон Төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, гаргасан саналыхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно.

Байнгын хороод зарчмын зөрүүтэй санал тус бүрээр санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг санал, дүгнэлтийн хамт Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо хамтарсан хуралдаанаар Байнгын хороодын санал нэг бүрийг хэлэлцэж, ил санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулах.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 65 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн зарчмын зөрүүтэй ажлын хэсгийн саналын томьёоллын уншиж танилцуулъя.

Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 64.1.4 дэх заалтын “төсвийн” гэснийг хасаж, 64.1.5 дахь заалтын “танилцуулгын талаар гишүүд тайлбар хийж, түүнтэй холбогдуулж асууж” гэснийг “танилцуулахтай холбогдуулан гишүүд асуулт асууж” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 65 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн зарчмын зөрүүтэй ажлын хэсгийн гаргасан саналын томьёоллыг уншиж танилцуулъя.

Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 69 дүгээр зүйлийн 69.1.4 дэх заалтын “хоёр дахь” гэснийг “3 дахь” гэж өөрчилж, мөн зүйлийн 4 дэх заалт буюу 70.3 дахь хэсгийн “төслийн талаар” гэснийг “төслийн хэлэлцүүлэг хийсэн талаар” гэж, мөн зүйлийн 70.1, 70.3 дахь хэсгийн “, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, нам, эвслийн бүлэг” гэснийг 70.2 дахь хэсгийн “болон дэд” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 65 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр асуух асуулттай гишүүд байна уу?

Байхгүй байна. /алх цохив/

Ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй нэг санал байна.

Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийн “дүгнэлт болон төсвийн нөлөөллийн дүн шинжилгээг” гэснийг “зөвлөмжийг гэж” гэснийг хасаж, мөн зүйлийн “42.2.2 дахь заалтын” гэсний дараах “дүгнэлтийг” гэснийг “энэ хуулийн 34.1-д заасан хууль зүйн дүгнэлтийг” гэж, мөн зүйлийн “Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны” гэснийг “Хүний хөгжил, нийгмийн бодлогын” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 12 гишүүн дэмжиж, 60 хувиар санал дэмжигдлээ.

Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 5 дугаар зүйл дээр асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Нэгтгэсэн төслийн 5 дугаар зүйлийн “70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсэг,” гэснийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 15 гишүүн нь дэмжиж, 75.0 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөх тухай хуулийн төслийн 6 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал байгаа юу?

Байхгүй байна. /алх цохив/

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 7 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал байгаа юу?

Байхгүй байна. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Одоо Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу

О.Номинчимэг гишүүн байна. О.Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Бүгдэд өдрийн мэнд хүргэе.

Энэ нөгөө хяналт шалгалтын түр хорооны даргалагч нь хэн байх вэ гэдэг саналыг ажлын хэсэг яах вэ О.Цогтгэрэл даргатай бас зөвшилцөөд оруулж ирж байгаа юм байна.

Тэгээд эндээс эхлээд тодруулъя гэж бодож байна.

Тэгээд саналын томъёолол гарахаар түр хорооны даргаар түр хороо байгуулах саналыг “анх санаачилсан гишүүнийг томилж ажиллуулна.” гэж байна. “Анх санаачилсан гишүүн” гэдгийг яг яаж тодорхойлох юм бэ?

Одоо ер нь ингээд нэг чухал асуудал байна гээд гурав, дөрвөөрөө нийлээд санаачилъя гээд явж байгаа ч юм байна.

Ямар ч байсан хуулиар 32 гишүүн гарын үсэг зурах ёстой байдаг. Тийм ээ. Энэ 32 гишүүнээсээ “анх санаачилсан гишүүн” гэдгийг яаж тодорхойлох юм? Нэгдүгээр асуулт.

Тэгээд тодорхойлж чадахгүй бол гишүүд дотроосоо татгалзсан тохиолдолд гэж байгаа. Тийм ээ. Дотроосоо гэж байгаа юм.

Яах вэ, би энэ асуудлыг хэлээд байгаа юм нь бид одоо байгаа зовлонгоо шийдэх гээд хууль руу хэтэрхий ийм хатуу хэм хэмжээ оруулаад гажуудал үүсгэчих вий дээ л гэж айгаад байгаа юм.

Ер нь О.Цогтгэрэл даргын яагаад үүнийг санаачилга болсон гэдгийг ойлгож байгаа л даа. 76-тай парламент түр хороо ажиллахдаа ямар байсан гэдгийг ойлгоод байгаа. Өмнө нь явсан түр хорооны ажлууд ч гэсэн гажуудалтай байсан. Ерөөсөө энэ дээр бид анхаарах ёстой. Процессын хувьд ч гэсэн сайжруулах юмнууд зөндөө байгаа юм.

Яах вэ, 76-тай парламентад хэт олонх нь Монгол Ардын намаас, тэгээд цөөхөн арван хэдэн Ардчилсан намын гишүүд байгаад энэ дээр тооны хувьд ч гэсэн, дуу хоолойгоо өргөх байдал дээр ч гэсэн хүчин мөхөстсөн юм байж магадгүй.

Гэхдээ бид чинь 2023 онд нэмэлт, өөрчлөлт хийгээд, тогтолцоо маань өөрчлөгдөөд байгаа. Харьцангуй баланстай 126 гишүүнтэй парламент ороод ирээд байгаа юм. Парламентын бүрэлдэхүүн.

Би өчигдөр нэлээн судаллаа л даа. Яг ийм нарийвчилсан дарга нь тийм байна, ийм байна гэсэн зохицуулалттай улс алга. Манайх хянан шалгалтын хуулийг нэлээн Бундестаг, Конгрессын хуулиудыг нэлээн судалж байж хийсэн юм. 2019 онд нэмэлт, өөрчлөлтийн дараа үүнийг 2021, 2022 онд баталсан байхгүй юу.

Тэгээд Бундестагийг нь ч гэсэн түр хороо байгуулах, бүрэлдэхүүн ямар байх, даргыг нь хэрхэн томилохтой холбоотой журмыг харахаар ерөөсөө ийм юм байхгүй байгаа юм.

Ер нь түр хороо гэдэг чинь өөрөө маш өргөн цар хүрээтэй чухал асуудал. Тийм ээ. Үндэсний хэмжээний, аюулгүй байдлын хэмжээний асуудал ч байна. Үнэхээр олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалахын төлөө асуудал ч байна.

Тэгээд энэ дээр ер нь ямар зарчим барьж даргаа сонгодог юм гэхээр ерөөсөө туршлага чадварыг нь хамгийн их хардаг. Энэ бол өөрөө олон нийтийн асуудал байгаа учраас туршлага чадвартай, дээр нь хараат бусаар үйл ажиллагаа явуулах чадвартай юу, үгүй юу гэдгийг нь харж байгаад тэгээд намын бүлгүүд зөвшилцөх нь зөвшилцөөд, эсвэл зөвшилцлийн механизмаараа шийддэг байгаа байхгүй юу.

Тэгэхээр одоо ингээд дахиад механикаар санаачлагч нь, анх санаачилсан гэдэг үг, нэр томьёо ороод ирэхээр яг яаж үүнийг тодорхойлох гээд байна вэ гэдэг асуудал үүснэ.

Яах вэ үүнээс гадна өөр дахиад зөндөө тайлбарууд байгаа. Гэхдээ би санал гаргасан байгаа учраас эхлээд асуултдаа хариулт авъя.

Ц.Сандаг-Очир: О.Номинчимэг гишүүний асуултад хууль санаачлагч О.Цогтгэрэл гишүүн хариулъя.

О.Цогтгэрэл гишүүний микрофон.

О.Цогтгэрэл: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Хэлэлцэх эсэх шатад явж байхад тодорхой гишүүдийн саналууд гарсан учраас ажлын хэсэг дээр зарчмын зөрүүтэй санал гаргаж томьёолсон. Ажлын хэсэг дэмжсэн.

Энэ саналын агуулга нь нэгдүгээрт нь “анх санаачилсан гишүүн”, хэрвээ гишүүн өөрөө татгалзвал түр хороо байгуулах санал тавьсан гишүүд дотроосоо буюу 32-оос дээш гишүүн дотроосоо. Хэрвээ ингэж сонгох шаардлагагүй гэж үзвэл түр хорооны хуралдаанд оролцсон буюу нэгдсэн хуралдаанаас байгуулагдсан түр хорооны гишүүдийн буюу 3 үе шаттай түр хороон даргалагчийн асуудлыг ярилцсан.

Тэр “анх санаачилсан гишүүн” гэдгийг бид ойлгохдоо, одоо ч гэсэн Улсын Их Хурлын гишүүнийг олон гишүүд өргөн барихдаа нэг гишүүн нь толгой бланк дээр явдаг. Яг энэ зарчмаараа ойлгож байгаа.

Ер нь энэ хууль дээр бас явцын дунд анх санаачилсан гишүүн болоод тодорхой гишүүд дээр ашиг сонирхлын зөрчил бас гарч магадгүй. Тэрийг бид бас мэдэхгүй, таахгүй.

Энэ асуудлыг энэ хуулийн заалт дээр бас тухайлан оруулах гэж үзсэнээ яг яг энэ Улсын Их Хурлын тухай хуулийнх нь шалгалтын тухай хуулийн 33.4 дээр нь маш тодорхой заасан байгаа юм билээ. Анх санаачилсан гишүүн магадгүй ашиг сонирхлын зөрчилтэй бол яах вэ гэдэг асуудлын хүрээнд бас энэ яригдаж байгаа байх гэж ойлгож байна.

Яг 33.4 дээр болохоор Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол уг гишүүнийг түр хорооны бүрэлдэхүүнд оруулахыг хориглоно гэсэн байгаа юм.

Тэгэхээр түр хорооны бүрэлдэхүүнд угаасаа орохгүй байгаа юм чинь хурал даргалах боломжгүй болж байгаа учраас энэ тусгайлан заах шаардлагагүй. Одоо хууль дээр ашиг сонирхлын зөрчлийг заасан байна гэж.

Дахиад нөгөө талаасаа тодорхой гишүүн дээр бас янз бүрийн хуульд заахаасаа гадна өөр асуудал байна гэж үзвэл ер нь энэ түр хорооны баримт

бичиг дээр түр хороонд анх санаачилсан гишүүний бланк дээр гарын үсэг зурахдаа гишүүд хоёр зүйлийг анхаарч сурах шаардлагатай. Тэрийгээ илүү мэдрэх болов уу гэж бодож байгаа юм. Тэр нь нэгдүгээрт нь түр хороо байгуулах эсэхийг дэмжиж байгаа.

Хоёрдугаарт нь, энэ хүн түр хороог даргалах магадлалтай юм байна гэдгийг энэ хүнийг дэмжиж байгаа эсэх дээр.

Тэгэхээр энэ өөрөө нэлээн өндөр босготой буюу 32-оос дээш гишүүн гарын үсэг зурж түр хороо байгуулагдаж байгаа болохоор энэ асуудлыг гишүүд бас олонхоороо зөв зүйтэй талаасаа харах байх. Парламент өөрөө зөвшилцлийн, ойлголцлын талбар учраас 32-оос дээш гишүүний саналыг авна гэдэг өөрөө тийм бас бага босго, бага шалгуур биш байх гэж бодож байгаа юм.

Тэгэхээр зарим Байнгын хорооны гишүүд тодорхой мэдээлэл муутай байж магадгүй. Энэ анхны томъёоллоосоо жоохон өөрчлөгдөөд зөвхөн цөөнх болоод цөөнхийн бүлэг дээр гэж байсан бол одоо анх санаачилсан нэг гишүүн буюу нэг гишүүний тухай. Хэрвээ энэ гишүүн боломжгүй болбол санаачилсан гишүүд буюу 32-оос дээш гишүүд.

Гуравдугаарт нь, Их Хурлын олонхоор гэдэг ийм гурван үе шаттайгаартайгаар цөөнхийн даргалагчийн тухай асуудал яригдаж байгаа шүү. Томъёолол, зарчмын зөрүүтэй санал ингэж гараад ажлын хэсэг дээр дэмжигдсэн шүү гэдгийг хэлье.

Ц.Сандаг-Очир: Болсон уу? О.Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Тийм. Тэгэхээр анх санаачилсан гишүүн гэдгийг хэн ямар гишүүний бланкан дээр энэ өргөдлөө гаргаж байгаагаар тодорхойлчихно гээд О.Цогтгэрэл дарга бас тайлбарлаж байгаа юм.

Тэгээд энэ дээр гол нь хуульч бид нарын хувьд чинь яах вэ, гажуудлаа засах гээд ингэж байж болно. Нэг шийдэл болж болно.

Гэхдээ энэ шийдэл хатуу хууль дээр орж байгаа шийдэл шүү дээ. Тийм ээ. Уян хатан механизм биш. Энэ хатуу хуулийн хэм хэмжээ болж байгаа. Үүнийг чинь дараа нь гажуудуулж хэрэглэх асуудлууд гарах вий дээ гэдгээр санаа зовниж байгаа байхгүй юу.

Тэгээд одоо юу гэдэг юм, өөрөө түр хороог ахална гэдэг бол маш туршлагатай, тэгээд хараат бусаар ажиллах буурьтай суурьтай хүмүүс байх ёстой. Улс төрийн зорилгоор үүнийг ашиглахгүй байх ёстой.

Тэгтэл юу гэдэг юм, одоо нэг аймаар популист нөхөр. Хууль дээр заасан ашиг сонирхлын зөрчлөөс гадна өөрөө “bias”¹-тай хүмүүс байгаа шүү дээ.

¹ Аль нэг талд хандлагатай, тал зассан, нэг талыг барьсан, хэн нэгэнд хэт найр тавьсан, ашиг сонирхлын нөлөөнд автах. г.м.

Вакцинд дотроо дургүй хүн байж болно. За юу. Вакцинд дургүй хүн вакцины талаар сонсгол хийе гээд 32 хүний саналыг аваад, тэгээд би санаачилсан юм чинь гээд би вакцины сонсголоо даргална гэж байна.

Тэгээд даргалах үүрэг чинь өөрөө энэ парламентыг юу гэдэг юм хянан шалгах үүргээ зөв явуулж байна уу, үгүй юу гэдэг дээр олон нийтэд парламентын итгэлийг бас бий болгоход маш чухал байхгүй юу.

Даргалагчийн үүрэг чухал учраас л бид хэн даргалагч нь ямар зарчмаар байх вэ гэдгээ ярьж байгаа.

Улс орнуудын парламент болохоор яах вэ, 3 зарчим барьдаг юм билээ. Би түрүүн хэлсэн. Манайд Бундестагийн буюу хоорондоо зөвшилцлийн хэлбэрээр уян хатан хийх. Угаасаа заалт нь ороод ирсэн. Бундестаг яадаг вэ гэхээр. Сая гишүүдтэй би Байнгын хороон дээрээ мэдээллийг нь өглөө.

Ерөөсөө яг манайх шиг даргын дэргэдэх зөвлөл буюу “Council of Elders”² гээд яг энэ тов дараалал, юу хэлэлцэх асуудлаа шийддэг бүлэг 23 хүнтэй байдаг. Энэ дээр бүлгийн дарга нар нь ордог.

Тэгээд энэ дээрээ бүлгийн дарга нар нь хоорондоо зөвшилцөөд, энэ асуудлыг буурьтай суурьтай, хараат бусаар хийчих хэн байна. Үүнийгээ шийдээд тэгээд оруулдаг болъё гэдэг санал.

Нөгөө талаараа зөв санаачлагч байхыг үгүйсгэхгүй. Тэр хүн даргалж болно. Гэхдээ хуулийн нөгөө гажуудал, хийдэл гэдэг шиг ийм завхрал... /минут дуусав/

Ц.Сандаг-Очир: О.Цогтгэрэл гишүүн хариулъя.

О.Цогтгэрэл: Бас тодорхой хэмжээний “bias”-тай, тодорхой хэмжээний зөрчилтэй, хуульд заасан ашиг сонирхлоос өөр ашиг сонирхол бүхий хүмүүс бас энд даргалах нөхцөл байдал үүсвэл яах вэ гэж байна л даа.

Тэгэхээр нэгдүгээрт нь би бас түрүүн хэлсэн. Энэ өөрөө 32-оос дээш гишүүн нь гарын үсэг зурахдаа энэ хүн даргалах магадлалтай юм байна гэдгийг нотолж байгаа нь ер нь парламентын 32-оос дээш гишүүний дэмжлэг гэдэг өөрөө бага тоо биш ээ.

Нэгэнт парламентын гишүүнээр сонгогдоод ороод ирсэн бол энэ хүнийг чи туршлагагүй юм байна, чи залуу юм байна, чи өөрөө тухайн сэдэв дээр өөр байдаг гэдэг ийм субъектив асуудлуудаас хандах нь нэгэнт гишүүний бүрэн эрх, нөгөө талаасаа 32-оос дээш гишүүн гэдэг бас бага тоо биш ээ. Бас ухамсартай шийдвэр, хариуцлагатай шийдвэр гаргах байх гэж бодож байна. Нэгдүгээрт нь.

² Ахмад, туршлагатай, удирдах эрх бүхий гишүүдийн бүрэлдэхүүнтэй зөвлөл.

Хоёрдугаарт нь, ер нь түр хорооны дарга гэдэг өөрөө дарга гэнгүүтээ өөрөө бүхнийг шийддэг хүн ерөөсөө биш. Түр хороо чинь өөрөө 7-гоос 11 билүү гишүүний бүрэлдэхүүнтэйгээр түр хороо байгуулагдаж байгаа. Түр хороонд олонх, цөөнхийн харьцаагаараа түр хороо бүрдэж байгаа. Түр хороо хэлэлцэх асуудлаараа ямар асуудлыг хэлэлцэх юм, ямар ямар гэрчийг дуудах юм гэдгийг түр хороо олонхоороо шийдэж байгаа.

Даргалагч дур мэдэн шийддэг асуудал энд бага учраас зөвхөн энэ хуралдааныг зохион байгуулахад тодорхой хэмжээнд олонх, цөөнхийн харилцаан дээр асуудлыг авч үзээсэй л гэж байгаа болохоос яг үндсэн агуулгын шийдлүүд бол Улсын Их Хурлын харьцаагаараа, тооны харьцаагаараа энэ дээр илүү явна гэж бодож байна.

Тэгэхээр энэ дээр асуудал гарахгүй байх.

Төгсгөлд нь тэр даргын зөвлөл дээр энэ асуудлыг хэн даргалахыг шийдээд, тэгээд Байнгын хороо болоод нэгдсэн чуулганаар хэлэлцэнэ гэвэл. Тэгвэл одоо байгаагаас ялгаагүй л байхгүй юу. Одоо тэгээд даргын зөвлөл дээр аль тал нь олонх байдаг билээ. Тэгээд чуулганаар ороод шийднэ гэвэл тэгвэл энэ хуульд ийм өөрчлөлт орохын хэрэг ерөөсөө байхгүй.

Тэгэхээр тэр санал бол тийм агуулгын өөрчлөлт авчрахгүй юм гэж бодож байна.

Ц.Сандаг-Очир: 1 дүгээр зүйл дээр гишүүд. Тодруулсан шүү дээ. Ахиад тодруулга 1 минут О.Номинчимэг гишүүнд.

О.Номинчимэг: Тийм.

Тэгэхээр одоо тэр чинь түр хорооны бүрэлдэхүүнээрээ л бүх юмаа шийддэг шүү дээ гэх юм бол таны анх энэ хуулийн төслийн үзэл санаа чинь байхгүй болчихоод байгаа байхгүй юу.

Та даргалагч чинь их чухал. Тийм болохоор даргалагчаа ингэж тохиръё гэдэг. Даргалагч чухал болохоор гэдэг юмыг л оруулж байсан шүү дээ.

Тэгээд даргалагч чинь тэгвэл намын харьяалал гэхээс илүү сэдвээсээ хамаарч болно. Гүйцэтгэх засаглалыг угаасаа хянан шалгах асуудал дээр энэ бол хараат бусаар ажиллаж чадах нь илүү цөөнх байна шүү дээ.

Нөгөө талаараа даргалагч хэн байх вэ гэхээр тэр агуулгын шаардлага нь ерөөсөө хараат бусаар ажиллах чадвартай, нэр хүндтэй, асуудлыг нэг тийш нь гуйвуулчихгүй зөв авч явах туршлагатай гээд ийм чадварууд байгаа байхгүй юу.

Тэгэхээр санаачлагч энэ чадварууд хоёр дандаа хамт байхгүй. Хамт байж болно. Мэдээж. Хамт байхгүй нөхцөлд хуулиар ийм юм хийгээд өгч байгаа болохоор жоохон гажуудал гарах эрсдэл байна.

Тэгэхээр зөвшилцлийн механизмаа ашиглаач ээ. Даргын дэргэдэх зүйл дээр одоо тэрийг шийддэггүй. Даргын дэргэдэх зөвлөл дээр бүх намын дарга нар байгаа. Үүнийгээ илэн далангүй ярилцдаг. Энэ зөвшилцлийн механизмаа ашиглаад уян хатан байгаач ээ л гэдэг ийм саналыг миний хувьд гаргасан юм.

Тэгээд одоо нөгөө ажлын хэсэг бас нэг санал гаргасан. Би бас нэг санал гаргасан байгаа болохоор хэрвээ ажлын хэсгийн санал дэмжигдэх юм бол миний саналаар санал хураахгүй. Зөвхөн уншигдаад өнгөрөх юм билээ.

Тэгэхээр гишүүд маань энэ ерөөсөө нэг намын юу гэдэг юм гэхээсээ илүү зарчмын асуудал, хууль хэрэглээний асуудал, гажуудлын асуудал ярьж байгаа учраас бас Та бүхэн маань бодож шийдвэрээ гаргаж өгөөч ээ л гэж би хүсэж байгаа юм.

Би саналаа хэлэхэд миний санал бол би Төрийн байгуулалтын байнгын хороонд өгсөн байгаа.

Ер нь түр хорооны даргыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13.3-д заасан зөвлөл буюу энэ бол даргын дэргэдэх зөвлөл. Бундестаг яг адилхан ийм журамтай юм. Зөвлөлийн саналыг үндэслэн түр хорооны гишүүдийн дотроос томилно оо л гэсэн юм байгаа. Зөвшилцлийн механизмыг нь л гаргаж өгч байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Одоо хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллын уншиж танилцуулъя.

1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйл буюу 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Түр хорооны даргаар түр хороо байгуулах саналыг анх санаачилсан гишүүнийг томилж ажиллуулах бөгөөд уг гишүүн өөрөө татгалзсан тохиолдолд түр хороо байгуулах санал тавьсан бусад гишүүд дотроосоо түр хорооны даргаа олонхын саналаар сонгоно. Хэрэв түр хороо байгуулах санал тавьсан гишүүд даргаа дотроосоо сонгох шаардлагагүй гэж үзвэл түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Энэ ажлын хэсгийн санал. Одоо О.Номинчимэг гишүүний гаргасан саналыг уншина. Уншаад танилцуулна.

Яг энэ санал дээр О.Номинчимэг гишүүн 33.8-д “Түр хорооны даргыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13.3-д заасан зөвлөлийн саналыг үндэслэн түр хорооны гишүүдийн дотроос томилно.” гэсэн санал гаргасан юм байна.

Эхлээд ажлын хэсгээс гаргасан саналаар санал хураалгана. Дэмжигдсэн тохиолдолд О.Номинчимэг гишүүний санал хураалгах шаардлагагүй. Дэмжигдээгүй тохиолдолд О.Номинчимэг гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулна.

Ингээд ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтдаа бэлдье. Гишүүд ээ. Ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/ Анхааралтай.

20 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 65.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дэмжигдсэн учраас О.Номинчимэг гишүүний гаргасан саналаар санал хураах шаардлагагүй.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал байгаа юу? 2 дээр. Байгаа юм байна.

Ажлын хэсгийн 2 дугаар зүйл дээр гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “Тогтвортой” гэснийг “Төсвийн тогтвортой” гэж өөрчилж, “24 дүгээр зүйлийн” гэсний дараа 24.2, 24.3 дахь хэсгийн “Хоёр” гэснийг “Гурав” гэж, мөн зүйлийн 24.2 дахь хэсгийн “хоёр” гэснийг “гурав” гэж, гэж нэмж, “, 24.4 дэх” гэснийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 14 гишүүн дэмжиж, 70.0 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалт хийх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал.

Байхгүй байна. /алх цохив/

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал.

Байхгүй байна. /алх цохив/

5 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал байгаа юу?

Байхгүй байна. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Одоо Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. /алх цохив/

Ажлын хэсгээс нэг санал байна.

Ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёололыг уншиж танилцуулъя.

1.Нэгтгэсэн хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “чуулганы нэгдсэн хуралдаанд” гэснийг “тухай хуулийн 21.28, 21.30-д заасан асуудлаар” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 15 гишүүн дэмжиж, 75.0 хувиар санал дэмжигдлээ.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулттай гишүүн байна уу? Саналтай гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал байгаа юу?

Байхгүй байна. /алх цохив/

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяраас ирсэн саналын томъёоллийг уншиж танилцуулъя.

1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн Цагдаагийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.5 дахь заалтын “гүйцэтгэх ажлын” гэснийг “гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажиллагааны” гэж: мөн заалтын “тусгай хяналтын” гэснийг “хууль сахиулах тусгай хяналтын” гэснийг хасах гэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 20 гишүүн дэмжээгүй байна. Санал дэмжигдсэнгүй.

Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулттай, саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал байгаа юу?

Байхгүй байна. /алх цохив/

Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Одоо Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяраас ирсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллийг уншиж танилцуулъя.

1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн Авлигын эсрэг хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийн “гүйцэтгэх ажлын” гэснийг “гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажиллагааны” гэж, мөн заалтын “тусгай хяналтын” гэснийг “хууль сахиулах тусгай хяналтын” гэснийг хасах гэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 20 гишүүн дэмжээгүй байна. Санал дэмжигдсэнгүй.

Авлигын эсрэг тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуух асуулттай, саналтай гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал байхгүй байна. /алх цохив/

Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал.

Байхгүй байна. /алх цохив/

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулттай гишүүн байна уу?

Байхгүй байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал.

Байхгүй байна. /алх цохив/

Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйл дээр асуух асуулттай гишүүн байна уу?

Байхгүй байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал байхгүй. /алх цохив/

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйл дээр асуух асуулттай гишүүн.

Алга байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал байна уу?

Байхгүй байна. /алх цохив/

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

1 дүгээр зүйл дээр асуух асуулт, саналтай гишүүн байна уу?

Байхгүй байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал.

Алга байна. /алх цохив/

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал.

Байхгүй байна. /алх цохив/

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуух асуулттай гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал.

Алга байна. /алх цохив/

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал.

Алга байна. /алх цохив/

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал.

Алга байна. /алх цохив/

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Б.Баярбаатар танилцуулна.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

Долоо.Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан нарын 40 гишүүн 2025.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан нарын 40 гишүүн 2025 оны 06 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг хэлэлцүүлье.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуух асуулттай гишүүн байна уу?

Байхгүй байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал байгаа юу?

Байхгүй байна. /алх цохив/

Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуух асуулт, саналтай гишүүн байна уу?

Алга байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал.

Алга байна. /алх цохив/

Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Э.Одбаяр гишүүн горимын санал гаргая гэж байна. Э.Одбаяр гишүүний микрофоныг өгье.

Э.Одбаяр: Гишүүдийнхээ өдрийн мэндийг хүргэе.

Тэгээд таныг тайлбарыг уншиж дуустал бас хүлээж байсан юм. Тэгээд бусад гишүүдээс горимын санал гараагүй учраас анхны хэлэлцүүлгээр нь баталъя. Зарчмын зөрүүтэй санал гараагүй учраас анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэдэг горимын санал гаргаж байна. Санал хураалгаж өгнө үү. Дарга.

Ц.Сандаг-Очир: Э.Одбаяр гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Анхны хэлэлцүүлгийг эцсийн хэлэлцүүлэгтэй хамтатган хэлэлцүүлье гэсэн зарчмын зөрүүтэй санал гаргаж байна. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

20 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Энэ хуулийн төсөл дэмжигдсэнтэй холбоотой Б.Жаргалан гишүүн ээ, нөгөө дагаж мөрдөх хугацааг баталсан өдрөөс нь гэхгүй бол одоо Үндэсний баяр наадмын бүх хөтөлбөр юмнууд гараад, сценар гараад ингээд одоогийн мөрдөгдөж байгаа хуулиараа явж байгаа. Тэгэхээр энэ өөрчлөлт ороогүй байна гэсэн үг.

Тэгэхээр энэ асуудалтай холбогдуулаад редакцын засвараар дагаж мөрдөх хуулийн хугацааг.

С.Зулпхар гишүүнийг дэмжсэнд хурлын тэмдэглэлд оруулаарай.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа танилцуулна.

Ингээд өнөөдөр Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар 13 хэлэлцэх асуудлаа амжилттай хэлэлцэж дууслаа.

Хуралдаа идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа. Хуралдаан хаасныг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 03 цаг 08 минут үргэлжилж, 15 цаг 28 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД